



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 36 (465)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*
- *Зарим шүүгчдэд зэрэг дэв олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Журам батлах тухай*
- *Хадгаламжийн банкны тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны есдүгээр сарын 28

№36 (465)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

577.	Равдангийн Зинамидэрт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 277	1073
578.	Самбуугийн Мөнхжаргалд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай	Дугаар 278	1074
579.	Норжмоогийн Тогтоход Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 279	1074
580.	Өндөрийн Дорждэрэмд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай	Дугаар 280	1074
581.	Баатарын Искрад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай	Дугаар 281	1074
582.	Цэндийн Сампилноровт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай	Дугаар 282	1075
583.	Чимэдийн Мягмарт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай	Дугаар 283	1075
584.	Сономын Лувсангомбод Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай	Дугаар 284	1075
585.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 285	1075
586.	Зарим шүүгчдэд зэрэг дэв олгох тухай	Дугаар 292	1078

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

587.	Журам батлах тухай	Дугаар 159	1078
588.	Хадгалэмжийн багшны тухай	Дугаар 165	1080

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

589.	Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 03	1098
------	--	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Равдангийн Зинамидэрт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Барилгын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж барилгын бүх төрлийн ажлын технологийг бүрэн эзэмшин үйлдвэрлэл, үйлчилгээ болон орон сууцны барилгуудыг чанарын өндөр үзүүлэлттэйгээр барьж ашиглалтад оруулан, барилгын салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Пума" ХХК-ийн

барилгын даамал Равдангийн Зинамидэрт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 278

Улаанбаатар
хот

**Самбуугийн Мөнхжаргалд Монгол Улсын
гавъяат барилгачин цол хүртээх тухай**

Нийслэл хотыг хөгжүүлэх III, IV ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, хотын дэд бүтцийг хөгжүүлэн цахилгаан, дулаан, усан хангамжийг сайжруулах, зам гүүр инженерийн шугам сүлжээ, үерийн далан суваг барих, нийслэлийн орон сууцны хорооллуудыг барилгажуулах, дагуул хотуудыг

хөгжүүлэх талаар гаргасан амжилт бүтээлийг нь үнэлж "Монголын архитекторуудын эвлэл"-ийн хүндэт ерөнхийлөгч Самбуугийн Мөнхжаргалд Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 279

Улаанбаатар
хот

**Норжмоогийн Тогтоход Монгол Улсын
шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол
хүртээх тухай**

Шинжлэх ухаан, төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хот байгуулалт, хөрсний судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний олон бүтээл туурвиж, шинжлэх ухааны байгууллагын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Улсын Их Хурлын гишүүн асан

Норжмоогийн Тогтоход Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 280

Улаанбаатар
хот

**Өндөрийн Дорждэрэмд Монгол Улсын
гавъяат барилгачин цол хүртээх тухай**

Барилгын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэл, үйлчилгээ, орон сууцны барилгуудыг чанартай барьж ашиглалтад оруулан барилгын материалын үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Шинэ барилга" ХХК-

ийн ерөнхий захирал Өндөрийн Дорждэрэмд Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 281

Улаанбаатар
хот

**Баатарын Искрад Монгол Улсын
гавъяат барилгачин цол хүртээх тухай**

Барилгын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж барилгын үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, орон сууцны олон арван барилгуудыг чанартай барьж ашиглалтад оруулан хөдөлмөрийн өндөр амжилт гаргасныг нь үнэлж "Хаш Өргөө" ХХК-ийн захирал

Баатарын Искрад Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

Цэндийн Сампилноровт Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээх тухай

Дархан, Хөтөлийн цементийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг олон жил чадамгай удирдан шинэ техник, технологи санаачлан үйлдвэрлэлд нэвтрүүлж, Монгол Улсад цементийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Хөтөлийн

"Цемент шохой" ХК-ийн шохойн цехийн дарга Цэндийн Сампилноровт Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

Чимэдийн Мягмарт Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээх тухай

Их барилгын салбарт олон жил үр бүтээл, идэвх зүтгэлтэй ажиллаж иргэний болон үйлдвэрлэлийн барилгуудыг чанартай бариулан ашиглалтад оруулж, мэргэшсэн ажилчин, ажилтан бэлтгэн дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Алтан өрх" ХХК-ийн барилгын

даамал Чимэдийн Мягмарт Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

Сономын Лувсангомбод Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээх тухай

Нийслэлийн орон сууцны хорооллууд, Дархан, Эрдэнэт хот зэрэг олон барилга байгууламжуудыг барьж байгуулах ажлыг удирдан зохион байгуулж, барилгын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж төр, нийгмийн ахмад зүтгэлтэн Сономын

Лувсангомбод Монгол Улсын гавъяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улсад барилгын салбар үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ, төрийн болон

төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХОДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Шагдарын Сономдагва - Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөх

2. Цэвэлсодномын Ганхүү - Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Сандагдоржийн Алтангэрэл - "Дэлгэр интернэшл" ХХК-ийн гагнуурчин

3. Чүлтэмийн Батбэх - Сүхбаатар аймгийн "Шарга" ХХК-ийн мужаан

2. Намжилын Атардэлгэр - "Нийслэл Өргөө" ХК-ийн бригадын дарга

4. Батаагийн Батчулуун - Нийслэлийн "Байгууламж" ХК-ийн гагнуурчин

5. Хорлоогийн Баяраа - Нийслэлийн "Сан" ХХК-ийн сантехникийн техникч
6. Гомбожавын Баярсайхан - Нийслэлийн "Хангайн нар" ХХК-ийн зөвлөх инженер
7. Жамъяншаравын Баярсайхан - Барилгын "Дорнын өргөө" ХХК-ийн инженер
8. Махбуриадын Бульдан - "Монгол керамик" ХК-ийн дэд захирал
9. Шарын Гүнжидмаа - "Одкон салхивч" ХХК-ийн гүйцэтгэх захирал
10. Уламбаярын Дарьсүрэн - Зэвсэгт хүчний барилгын цэргийн 017 дугаар ангийн барилгачин, ахлах ахлагч
11. Цэдэвийн Дашдорж - Барилга, хот байгуулалтын яамны дэд сайд
12. Дашбалжирын Дашдулам "Гранд Перфект" барилгын сургалтын төвийн захирал
13. Лувсаншаравын Дугармаа - Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хяналтын инженер
14. Бохатханы Жирен - Баян-өлгий аймгийн Засаг даргын орлогч
15. Жигжидийн Зулзагабаатар - Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
16. Сэрээтэрийн Ламжав - Зураг төслийн "Идеал групп" ХХК-ийн ерөнхий захирал
17. Чүлтэмийн Лувсанцэвээн - Архангай аймгийн "Цагаан сүмбэр" ХХК-ийн барилгын даамал
18. Жанбарбайн Марат - Баян-өлгий аймгийн "Жол" ХХК-ийн ерөнхий инженер
19. Долгорын Мижидсүрэн - "Барилгын

- бирж" ХХК-ийн ерөнхий захирал
20. Батаагийн Мөнхжаргал - "Ачлал трейд" ХХК-ийн ерөнхий захирал
21. Гомбын Мягмар - Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн зохицуулалтын газрын дугаа
22. Пэрэнлэйн Намнансүрэн - Нийслэлийн "Өгөөж хишиг" ХХК-ийн өрлөгчин
23. Хавдалын Намхай - Барилга-Архитектур корпорацийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан
24. Дамдинжавын Солонго - Монгол - Оросын хамтарсан "Инкон" ХХК-ийн төлөөлөгч
25. Сандуйжавын Сүхбаатар - Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
26. Маамуугийн Цэвээн - Увс аймгийн барилгын "Өрнөл-Увс" ХХК-ийн ерөнхий захирал
27. Ганжуурын Цэрмаа - Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хэлтсийн дарга
28. Лханаажавын Цэцгээ - "Богда холдинг" ХХК-ийн эдийн засагч
29. Рэнцэнгийн Чогдгаваа - "Мон Инж Бар" ХК-ийн ахлах инженер
30. Дарийн Чулуунбат - Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
31. Цэдэндоржийн Энхбаяр - Азийн хөгжлийн банкны Орон сууцны санхүүжилтийн төслийг удирдах албаны дарга
32. Батмөнхийн Энхболд - "Барилга" корпорацийн ерөнхий менежер

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Баасангийн Баярбямба - Батлан хамгаалах их сургуулийн Барилга орон сууцны тасгийн дарга
2. Маналсүрэнгийн Жамбалсүрэн - ЗХЖШ-ын Ар талын газрын барилга орон

- сууцны хэлтсийн ерөнхий инженер, дэд хурандаа
3. Сэрээдэндэвийн Цэнд-Аюуш - ЗХЖШ-ын Ар талын газрын барилга орон сууцны хэлтсийн инженер, дэд хурандаа

ХОДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Мантааны Бадамдорж - Монгол-Оросын хамтарсан "Инкон" ХХК-ийн ахлах мастер
2. Жасранжавын Бадмаев - Нийслэлийн "Стройка" ХХК-ийн ерөнхий инженер
3. Какешийн Балагаз - Баян-Өлгий аймгийн "Суат" ХХК-ийн нярав
4. Намбуугийн Баттөр - Нийслэлийн "Бөх зам" ХХК-ийн ерөнхий захирал
5. Адъяагийн Батхүү - Архангай аймгийн "Цагаан сүмбэр" ХХК-ийн мужаан
6. Цэвэгжавын Бат-Эрдэнэ - "Си Эй Эс интернейшл" ХХК-ийн захирал
7. Баасанжавын Баянтуул - Барилга, хот байгуулалтын яамны Хөрөнгө оруулалт, хамтын

- ажиллагааны газрын орлогч дарга
8. Нямын Бүдүүнсайхан - Сүхбаатар аймгийн "Шарга" ХХК-ийн жолооч
9. Рахметийн Гажайв - Баян-Өлгий аймгийн барилга угсралтын "Монстрой-Эра" ХХК-ийн ерөнхий инженер
10. Эрдэнийн Ганзориг - Барилга, хот байгуулалт нийтийн аж ахуйн үндэсний төвийн дэд дарга
11. Нанзадын Ган-Эрдэнэ - Нийслэлийн "Геокад" ХХК-ийн захирал
12. Сэрээтэрийн Даваз - Ховд аймгийн "Ховдын Тулга" ХХК-ийн ерөнхий инженер
13. Цэрэндоржийн Далай - Хөвсгөл аймгийн



"Уул өвгөд" ХХК-ийн барилгын даамал
 14. Пунцагдоржийн Дорж - "Богда холдинг" ХХК-ийн хяналтын ерөнхий инженер
 15. Юндэндоржийн Доржпалма - Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
 16. Бадмаарагийн Дөлбадрах - Нийслэлийн "Өгөөж хишиг" ХХК-ийн засал чимэглэлчин
 17. Долгорын Жадамба - Төв аймгийн барилгын "Өгөөмөр уул" ХХК-ийн бригадын дарга
 18. Чойжилын Жаргалсайхан - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
 19. Анисийн Жубай - Баян-Өлгий аймгийн барилга угсралтын "Зах-Бек" ХХК-ийн захирал
 20. Дашийн Жүдхүү - Нийслэлийн "Таван үндэс" ХХК-ийн дэд захирал
 21. Банзрагчийн Ичинхорлоо - Булган аймгийн "Нэрст" ХХК-ийн барилгын даамал
 22. Давидын Мадгаа - Цахилгаан, сантехник угсралтын "Хүрд" компанийн ерөнхий менежер
 23. Нацагийн Мөнхжаргал - Нийслэлийн "Индустр" ХХК-ийн гүйцэтгэх захирал
 24. Лувсанцэрэнгийн Мягмарсүрэн - Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хяналтын инженер
 25. Санждоржийн Намжилмаа - Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн
 26. Цэрэндоржийн Нарангэрэл - Архангай аймгийн Шинэ хүч констракшн ХХК-ийн захирал
 27. Чулуунбаатарын Наранцэцэг - Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төвийн мэргэжилтэн
 28. Түдэвийн Нэргүй - Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
 29. Дорлигийн Нямхүү - Монгол-Оросын хамтарсан "Инкон" ХХК-ийн гапуурчин

30. Галсанцэрэнгийн Нямцогт - Нийслэлийн "Архитектур" нэгдлийн архитектор
 31. Солийн Ордон-Монголын Архитекторуудын эвлэлийн хүндэт зөвлөх
 32. Абзалын Октябрь - Баян-Өлгий аймгийн "Ернар" ХХК-ийн ерөнхий инженер
 33. Балдангийн Оюун - Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төвийн мэргэжилтэн
 34. Луандаагийн Өлзийбаяр - Барилгын "Дорнын өргөө" ХХК-ийн бетон арматурчин
 35. Дагвын Пүрэвсүрэн - Хөвсгөл аймгийн "Мөнх-Өргөө" ХХК-ийн гапуурчин
 36. Содномдаржаагийн Сандагдорж - Төв аймгийн барилгын "Буянт гол" ХХК-ийн захирал
 37. Самдангийн Төмөрбаатар - Нийслэлийн "Хотын зам" ХХК-ийн ерөнхий инженер
 38. Мухамедийн Халура - Баян-Өлгий аймгийн "Суат" ХХК-ийн эксковаторчин
 39. Халзангийн Хишигжаргал - "Бетон арматур" ХХК-ийн лабораторийн эрхлэгч
 40. Амгалангийн Цогзолмаа - Төв аймгийн барилгын "Буянт гол" ХХК-ийн даамал
 41. Онгойн Цэвээнрэгзэн - Барилгын "Дорнын өргөө" ХХК-ийн цахилгаанчин
 42. Очирын Цэрмаа - "Ханын материал" ХК-ийн хүний нөөцийн менежер
 43. Чойжилын Цэрэнбат - "Инженер геодези" ХХК-ийн зөвлөх инженер
 44. Дамирангийн Цэрэнлхам - Нийслэлийн "Сан" ХХК-ийн инженер
 45. Шагдарсүрэнгийн Цээбадар - "Нийслэл Өргөө" ХК-ийн бригадын дарга
 46. Дэлгэрбатын Чулуунрагчаа - Өмнөговь аймгийн барилга угсралтын "Говь гурван сайхан" ХХК-ийн жолооч
 47. Санрагийн Ширэндэв - "Эрхи" ХХК-ийн цахилгааны хэсгийн ахлах
 48. Баатарын Энхбаяр - Төв аймгийн барилгын "Тусгал төв" ХХК-ийн ерөнхий инженер
 49. Хандын Эрдэнэбат - Нийслэлийн "Байгууламж" ХК-ийн дулаалагч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Төмөрбаатарын Ринчидэндэв - Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 017 дугаар ангийн орлогч, дэд хурандаа
 2. Оюундалайн Сугар - Зэвсэгт хүчний Барилгын цэргийн 017 дугаар ангийн албаны дарга, дэд хурандаа

3. Гомбосүрэнгийн Цогтсайхан - ЗХЖШ-ын Ар талын газрын барилга орон сууцны хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Дугаар 292

Улаанбаатар хот

Зарим шүүгчдэд зэрэг дэв олгох тухай

Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 33 дугаар зүйл, "Шүүгчид зэрэг дэв олгох журам"-ын 2.2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн "Шүүгчид зэрэг дэв олгох журам"-ын 2.1 дэх хэсэгт заасан болзлыг хангасан дараах шүүгчдэд Монгол Улсын шүүхийн "Тэргүүн түшээ" зэрэг дэв олгосугай. Үүнд:

1. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч С. Батдэлгэр
2. Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д. Батсайхан

3. Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц. Амарсайхан

4. Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн О. Зандраа

5. Улсын дээд шүүхийн шүүгч Б. Бат-Эрдэнэ

6. Улсын дээд шүүхийн шүүгч Л. Бямбаа

7. Улсын дээд шүүхийн шүүгч А. Доржготов

8. Улсын дээд шүүхийн шүүгч Б. Доржготов

9. Улсын дээд шүүхийн шүүгч Д. Тунгалаг

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 5-ний өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 13.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх арга хэмжээнд зарцуулан хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

Л.Одончимэд, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 171 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД**
**Засгийн газрын 2006 оны 159 дүгээр
тогтоолын хавсралт**

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /цаашид "сан" гэх/ -гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, ажилгүй иргэдэд хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнд зориулагдана.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг төвлөрүүлэх, уг сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулалт санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн албад гүйцэтгэнэ.

1.4. Энэхүү журмын хэрэгжилт болон сангийн бүрдүүлэлт, санхүүжилт, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах асуудлыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

Хоёр. Сангийн бүрдүүлэлт

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

2.1.1. Улсын Их Хурлаар батлагдсан тухайн жилийн улсын төсвийн орлогоос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуваарилсан хөрөнгө;

2.1.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн тухайн жилийн төсвийн орлогоос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хуваарилсан хөрөнгө;

2.1.3. ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос хуулийн дагуу зарцуулах хөрөнгө;

2.1.4. сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүүгийн орлого;

2.1.5. олон улсын байгууллага, гадаад орноос олгосон зээл, тусламжийн хөрөнгө;

2.1.6. олон улсын байгууллага, гадаад орон, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс санд оруулсан хандивын хөрөнгө;

2.1.7. аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, гадаадын иргэнийг ажлын байраар хангаж орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөр;

2.1.8. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2-т заасан төлбөр;

2.1.9 бусад эх үүсвэр.

Гурав. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, санхүүжилт

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд улсын хэмжээний төвлөрсөн сан, орон нутгийн дэд сантай байна.

3.2. Орон нутгийн төсвөөс дэд санд олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улсын төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрсөн санд олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагыг төлөвлөж, жил бүрийн 8 дугаар сарын 10-ны дотор хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрсөн санд жил бүр улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээ болон сангийн орлого, зарлагын жилийн төлөвлөгөөг хянан улсын хэмжээгээр нэгтгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг тусган жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.5. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын төсвийг тухайн жилийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын зорилт, эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.6. Санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага сангийн орлого, зарлагыг хянаж жил бүрийн төсвийн төлөвлөгөөнд тусгана.

3.7. Улсын Их Хурлын чуулганаар баталсан улсын төсвөөс олгох хөрөнгийг орлогын гүйцэтгэлтэй уялдуулан улирал бүр санхүүжүүлэх бөгөөд тухайн улирал, жилд дутуу хийгдсэн санхүүжилтийн хөрөнгийг дараа улирал, жилд нөхөн олгоно.

3.8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

Дөрөв. Сангийн зарцуулалт

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулна:

4.1.1. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох;

4.1.2. ажилд зуучлах;

4.1.3. мэргэжлийн сургалтад

хамруулах;

4.1.4. нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

4.1.5. ажил олгогчийг дэмжих;

4.1.6. хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

4.1.7. хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.8. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг турших, нэвтрүүлэх;

4.1.9. орлогын тухайн жилийн төлөвлөгөөнөөс давсан хэсгийг хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эвхийн ажиллагааг хангах, ажилтнуудаа сургах, давтан сургах, урамшуулахад зарцуулах.

4.2. Олон улсын байгууллага, хандивлагч орноос олгосон зээл, тусламжийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнана.

4.3. Төвлөрсөн сангаас орон нутагт хуваарилах хөрөнгийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улирлаар хуваарилан батална. Энэхүү хуваарийг санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлж байна.

4.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын төрөл, хамрагдах иргэнд тавигдах нөхцөл, болзол, шалгуурыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ.

4.5. Улсын хэмжээний төвлөрсөн сангийн харилцах дансны 1 дүгээр болон 2 дугаар гарын үсгийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга болон сан хариуцсан нягтлан бодогч, орон нутгийн дэд сангийн харилцах дансны 1 дүгээр болон 2 дугаар гарын үсгийг хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга болон нягтлан бодогч тус тус зурна.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдагчдыг бүртгэх, сангаас олгох хөрөнгийн хэмжээг тодорхойлох, тогтоосон хугацаанд олгох, хяналт тавих, зохион байгуулах үүргийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба гүйцэтгэнэ.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалтад дараахь байдлаар хяналт тавина:

5.2.1. улсын хяналтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын газар, Үндэсний аудитын газар тус тусын эрх хэмжээний дагуу;

5.2.2. орон нутагт улсын хяналтыг эдгээр байгууллагын харьяа орон нутгийн алба хэрэгжүүлнэ.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

5.3.1. улирлын тайланг сумын хөдөлмөрийн асуудал эрхэлсэн ажилтан дараа улирлын эхний сарын 5-ны дотор аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн алба дараа улирлын эхний сарын 15-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус ирүүлнэ;

5.3.2. хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 5-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тус тус гаргаж хөдөлмөрийн болон санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.4. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сангийн орлого, зарлагын тайланг хуулийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын төв байгууллагад хүргүүлж байна.

5.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлан, мэдээний маягтын загварыг санхүү төсвийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж мөрдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар хот

Хадгаламжийн банкны тухай

Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 10, мөн хуулийн 33, 46-54 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол банктай зөвшилцсөний дагуу Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хадгаламжийн банкныг "Хадгаламжийн банк" хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ болгон өөрчлөн зохион байгуулсугай.

2. "Хадгаламжийн банк" ХХК-ийн дүрмийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

3. "Хадгаламжийн банк" ХХК-ийг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээг 2 дугаар хавсралт, "Хадгаламжийн банк" ХХК-ийг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

4. "Хадгаламжийн банк" ХХК-ийг худалдах доод үнийг 12.000.000.000 /арван хоёр тэрбум/ төгрөгөөр тогтоосугай.

5. Төрийн өмчийн хэрээ /Д.СУГАР/-нд даалгах нь:

а) "Хадгаламжийн банк" ХХК-ийг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-ын зар мэдээг

дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж ажилласугай;

б) "Хадгаламжийн банк" ХХК-ийг хувьчлах уралдаант шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-ын дагуу зохион байгуулж явуулсугай;

в) "Хадгаламжийн банк" ХХК-ийг хувьчлах уралдаант шалгаруулалтад ялсан худалдан авагчтай "Уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам"-д заасан болзол, нөхцөлийн талаар хэлэлцэж, "Худалдах, худалдан авах тухай гэрээ" байгуулахыг зөвшөөрсүгэй.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 294 дүгээр тогтоолын 1, 2 дугаар зүйлийн "Хадгаламжийн банк" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

Засгийн газрын 2006 оны 165 дугаар
тогтоолын 1 дүгээр хэвсрэлт

"ХАДГАЛАМЖИЙН БАНК" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл

Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн, Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл", Засгийн газрын 2006 оны 77 дугаар тогтоолд заасны дагуу Хадгаламжийн банкныг хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-ийн хэлбэрээр өөрчлөн байгуулав.

2 дугаар зүйл

"Хадгаламжийн банк" ХХК нь Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн хөрөнгө хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс бусдад зээлдүүлэх, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, мөнгөн гүйлгээ, гадаад дотоод зээл тооцооны нийтлэг ажил, үйлчилгээг эрхлэх чиг үүрэгтэй, Монгол Улсын төрийн өмч дагласан, хязгаарлагдмал хариуцлагатай буюу хаалттай компани хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд хувь нийлүүлэгчээс тусгайлан өмчилсөн эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээх, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцах, шүүх, арбитраж өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, Төв банкнд өөрийн данстай, энэ дүрэмд заасан үйл ажиллагаа явуулж, ашиг олох зорилготой Монгол Улсын хуулийн этгээд мөн.

3 дугаар зүйл

Монгол банк болон төрийн захиргааны бүх шатны байгууллага нь "Хадгаламжийн банк" ХХК /цаашид "Банк" гэх/-ийн хуулийн дагуу явуулж буй үйл ажиллагаа, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох эрхгүй.

4 дүгээр зүйл

Банк нь Монгол Улсын хуулиар хориглоогүй бөгөөд Монгол банкнаас зөвшөөрсөн санхүүгийн ажил, үйлчилгээг эрхлэж болно.

5 дугаар зүйл

Банкны оноосон нэрийг монголоор "Хадгаламжийн банк" ХХК, англиар "Savings Bank of Mongolia" LLC гэнэ.

6 дугаар зүйл

Банкны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 9, Жуулчны гудамж 6, Утас: (976-11) 31-08-35, Факс: (976-11) 31-20-49,

Электрон шуудангийн хаяг: savbank@magicnet.mn

7 дугаар зүйл

Банк нь өөрийн нэгжийг байгуулан ажиллам болно. Банкны нэгжийг Монгол банкны журамд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, хадгаламжийн касс, валютын цэг хамаарч болох бөгөөд салбар, төлөөлөгчийн газар, валютын цэг байгуулах хүсэлтийг Монгол банкнд гаргаж, зөвшөөрөл авсан байна. Салбар, төлөөлөгчийн газар болон бусад нэгж нь банкны нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

7.1. "Салбар" гэж банкны оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдэг тусгай нэгжийг хэлнэ.

7.2. "Төлөөлөгчийн газар" гэж банкны оршин байгаа газраас өөр газар байрладаг бөгөөд банкны аливаа үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн банкны хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, банкны нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйлдэл хийдэг нэгжийг хэлнэ.

7.3. "Банкны тооцооны төв" гэж банкны бүх төрлийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг нэгжийг хэлнэ. Үүнд зээл олгох үйл ажиллагаа хязгаарлагдмал байж болно.

7.4. "Банкны хадгаламжийн касс" гэж иргэдийн хадгаламж, түүнтэй адилтгах бүх төрлийн, мөн бэлэн бус тооцооны хязгаарлагдмал үйлчилгээ эрхэлдэг боловч зээл олгох болон хуулийн этгээдийн харилцах дансны ажил, үйлчилгээ эрхэлдэггүй нэгжийг хэлнэ.

7.5. "Банкны валютын цэг" гэж гадаад валют худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийг хэлнэ.

8 дугаар зүйл

Банк нь өөрийн нэр бүхий тэмдэг, хэвлэмэл хуудас, логотой байна. Тэмдэг нь банкны албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлүүдийг баталгаажуулах зорилготой. Банкны захиргаанаас итгэмжлэн хариуцуулсан этгээд тэмдгийг хадгална.

Хоёр. Банкны дүрмийн сан

9 дүгээр зүйл

Банкинд хувь хөрөнгө оруулсан этгээд нь Гягц хувь нийлүүлэгч/ Монгол Улсын Засгийн газар

бөгөөд түүний нэрийн өмнөөс төрийн өмчийн төлөөллийг Төрийн өмчийн хороо хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл

10.1. Банкны дүрмийн сан нь 8.031.000.000 /найман тэрбум гучин нэгэн сая/ төгрөг болно.

10.2. Банк нь 8.031.000 /найман сая гучин нэгэн мянган/ ширхэг энгийн хувьцаатай.

10.3. Банкны нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 /нэг мянган/ төгрөг байна.

10.4. Банк нь банкны Хувь нийлүүлэгчдийн бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд хувь нийлүүлэгчийн нэр, хаяг, эзэмшиж буй хувьцааны тоо, хувьцааг шилжүүлсэн тухай тэмдэглэл, хувьцааг шилжүүлэн авсан этгээдийн нэр, хаяг болон хуулиар шаардсан өөр бусад мэдээллийг тусгана.

10.5. Банк нь Хувь нийлүүлэгчийн бүртгэлд тусгасан тоо бүхий хувьцааг эзэмших эрхийг баталсан гэрчилгээг /"хувь нийлүүлэгчийн гэрчилгээ"/ хувь нийлүүлэгчид олгоно. Энэхүү гэрчилгээнд банкны тэмдгийг дарж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон банкны Гүйцэтгэх захирал гарын үсэг зурна.

11 дүгээр зүйл

Хувь нийлүүлэгч нь дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, банк төлбөрийн чадваргүй болсон, дамлуурсан, татан буугдсан тохиолдолд бий болсон алдагдлыг дүрмийн санд оруулсан хувь хөрөнгөөрөө нөхнө.

12 дугаар зүйл

Банкны дүрмийн санд хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь банкны өмч болох бөгөөд хувь нийлүүлэгч нь түүнийг Монгол банкны зөвшөөрснөөр бусдад худалдахаас бусдаар буцааж авах эрхгүй.

13 дугаар зүйл

Банк нь өөрийн хөрөнгийг хуулийн хүрээнд эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй. Банкны үйл ажиллагаанаас олсон орлого нь банкны өмчлөлд байна.

Гурав. Банкны үйл ажиллагаанд тавих шаардлага, хориглох зүйл

14 дүгээр зүйл

Банк нь үйл ажиллагаагаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Монгол банкнаас батлан гаргасан дүрэм, журмын дагуу явуулна.

15 дугаар зүйл

Банкны ажилтнууд дараахь шаардлагыг хангаж ажиллана:

15.1. Аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх;

15.2. Албан үүрэгтээ үнэнч шударгаар хандаж, банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, садан төрөл болон бусад хүмүүст хуулиас гадуур давуу байдал олгохгүй байх;

15.3. Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан материал, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар, нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд өөрөөр заагаагүй бол бусдад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.

Дөрөв. Банкны удирдлага

16 дугаар зүйл

16.1. Банкны эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчийн хурал байна. Хувь нийлүүлэгчийн хурлын бүрэн эрхийг Төрийн өмчийн хороо хэрэгжүүлнэ.

16.2. Банкны хувь нийлүүлэгчийн хурал нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

16.3. Банк нь нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлтэй /цаашид "ТУЗ" гэх/ байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Төрийн өмчийн хороо томилно.

17 дугаар зүйл

ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангуулах, хурлыг зохион байгуулж даргалах, шийдвэрийн төсөл боловсруулах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хянаж баталгаажуулах үүрэгтэй. ТУЗ-ийн дарга нь банкны захиргааны /өдөр тутмын/ бүрэн эрхийг хэрэгжүүлэхгүй. ТУЗ-ийн даргын түр эзгүйд үүргийг нь түүний томилсон, эсхүл ТУЗ-өөс томилогдсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

18 дугаар зүйл

ТУЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.

19 дүгээр зүйл

ТУЗ-ийн гишүүн нь өөр банкны байгууллагын удирдлагад хавсран ажиллаж болохгүй.

20 дугаар зүйл

ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл

ТУЗ-ийн ээлжит хурлыг сар бүрийн 4 дэх долоо хоногийн Пүрэв гаригт банкны төв байранд хийнэ. Хэрэв уг өдөр нь нийтээр амрах амралтын өдөр байвал дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ. ТУЗ-ийн гишүүдэд хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө биечлэн гардуулан өгөх, эсхүл баталгаат шуудан, факс, электрон шуудангаар банкны нарийн бичгийн дарга хүргүүлнэ.

22 дугаар зүйл

ТУЗ-ийн ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд болон компанийн гүйцэтгэх захирлын санаачилга шаардлагаар хуралдуулна.

23 дугаар зүйл

ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

24 дүгээр зүйл

Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл

ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.

26 дугаар зүйл

ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хуралдаанд бичгээр саналаа өгөхөөс гадна телефон утас, түүнтэй адилтгах холбооны хэрэгслийн тусламжтайгаар оролцож болно. Гэхдээ хуралд оролцож буй бүх хүмүүс яриаг сонсох, түүнтэй ярилцах боломжтой байна. Ийм хэлбэрийг хуралд биеэр оролцсонд тооцно.

27 дугаар зүйл

ТУЗ-ийн гишүүд төлөөлөх үүргээ хэрхэн биелүүлж байгаа, тус банкинд холбогдох бусад хүчин зүйлийг харгалзан гишүүдэд олгох урамшууллын хэмжээг ТУЗ өөрөө тогтооно.

28 дугаар зүйл

Банк нь нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй Хянан шалгагчдын зөвлөлтэй /цаашид "ХШЗ" гэх/ байх бөгөөд ХШЗ-ийн гишүүдийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Төрийн өмчийн хороо томилоно. ХШЗ нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

29 дүгээр зүйл

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулах бөгөөд тэр нь ТУЗ-д ажлаа хариуцан тайлагнана. Гүйцэтгэх захирал нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол банкнаас батлан

гаргасан журамд заасан шаардлагыг хангасан байна.

30 дугаар зүйл

Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэггүйгээр үйл ажиллагаа явуулна.

31 дүгээр зүйл

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний /цаашид "гэрээ" гэх/ үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, журам, хөлс, урамшууллын хэмжээг тусгаж өгнө.

32 дугаар зүйл

32.1. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:

32.1.1. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Монгол банкнаас Банкны тухай хуулийн заалтад нийцүүлэн өгсөн үүрэг даалгавар, ТУЗ-ийн шийдвэрийг биелэлтийг хангуулах;

32.1.2. ТУЗ болон үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, өөрийн банкны санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

32.1.3. Банк, банкны хадгаламж эзэмшигчид, харилцагчийн эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан, банк, түүний салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, хадгаламжийн касс, валютын цэгийн үйл ажиллагааг зохицуулан удирдах;

32.1.4. Үүрэг гүйцэтгэх явцад олж мэдсэн банк, банкны харилцагчийн талаархи мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;

32.1.5. ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтсан банкны орон тоо, ажилтнуудын үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;

32.1.6. Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;

32.1.7. Банк, түүний салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, хадгаламжийн касс, валютын цэгийн удирдлага, ажилтнуудыг томилох, ажлаас чөлөөлөх;

32.1.8. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд банкны нэрийн өмнөөс

баталгаа, батлан даалт гаргах, гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурах;

32.1.9. Банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

32.1.10. Банкны боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

32.1.11. Санхүүжилт, зээлжүүлэлттэй холбогдсон хөрөнгийн баталгаа гаргах, холбогдох гэрээний дагуу шаардлагатай мэдээ, тайланг харилцагчаас шаардан авах, тайлан тэнцэлтэй нь танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаанд авах, дансны гүйлгээг түр хаах;

32.1.12. Банкний төлөөлж нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;

32.1.13. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд салбар, нэгжийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, нэг этгээдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох, зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж, хяналт тавих;

32.1.14. Шаардлагатай бол Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хадгаламж эзэмшигч, харилцагчдын болон хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тухайн салбар, нэгжийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон тусгай дүрэм, журам гаргах, салбар, нэгжийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тогтоох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

32.1.15. Банкны хөрөнгийг захиран зарцуулах, төлбөрийн баримтад гарын үсэг зурах;

32.1.16. Гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

32.2. Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэмд болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх, үүргээ дэд захирал зэрэг албан тушаалтнуудад шилжүүлж болно. Энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

32.3. Банкний төлөөлж гэрээ байгуулах этгээд нь Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан өөрт холбогдох этгээд байгаа бол энэ тухайгаа нэн даруй ТУЗ-д мэдэгдэх үүрэгтэй.

33 дугаар зүйл

Монгол Улсын хууль тогтоомж, Монгол банкнаас тогтоосон журам болон гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу ТУЗ нь Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлж болох бөгөөд энэ тохиолдолд Гүйцэтгэх захирлыг шинээр томилох хүртэл үүрэг гүйцэтгэгчийг түр томилон ажиллуулна.

34 дүгээр зүйл

Гүйцэтгэх захирал нь банкны ажлын үр дүнг ТУЗ-д тогтмол тайлангаж, сар бүрийн эцэст банкны

үйл ажиллагааны талаар албан мэдээлэл гарган өгч байна.

35 дугаар зүйл

Гүйцэтгэх захирал нь өөрийн хүсэлтээр албан үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрхтэй. Гүйцэтгэх захирал энэ тухайгаа ТУЗ-д бичгээр мэдэгдэх бөгөөд ТУЗ эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд тэрээр албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх үүрэгтэй.

36 дугаар зүйл

ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хөтлөх, ТУЗ-ийн даргад туслах, ТУЗ-ийн бичиг хэрэг, техникийн шинжтэй бусад ажил гүйцэтгэх үүрэгтэй нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн шийдвэрээр томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг банкны аль нэг ажилтанд хавсруулан гүйцэтгүүлж болно.

37 дугаар зүйл

Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг зориулалтын дэвтэрт хөтөлж, хуралд оролцогчдын гаргасан санал, хурлын бүх явцыг тодорхой тэмдэглэнэ. Хурлын тэмдэглэлд тухайн хурлаас гаргасан тогтоолуудыг хавсаргана.

Тав. Банкны санхүү, бүртгэл

38 дугаар зүйл

Банк нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хэвлүүлнэ.

39 дүгээр зүйл

Санхүүгийн тайлан нь тайлан тэнцэл, орлого, үр дүнгийн тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, монгол гүйлгээний тайлан болон нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

40 дүгээр зүйл

Санхүүгийн тайлангуудын үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

41 дүгээр зүйл

Банк нь Дотоод хяналт шалгалтын нэгжтэй байна.

42 дугаар зүйл

Дотоод хяналт шалгалтын нэгж нь банкны өдөр тутмын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажиллагаа нь холбогдох заавар, журмын дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавьж, банкны төв болон салбар, нэгжүүдийн өдөр тутмын төсөв, орон тоо, цалингийн сан, тайлан гаргалт, татвар төлөлт зэрэг нь хууль тогтоомж, банкны эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэрт нийцэж байгаа эсэхийг шалгаж, холбогдох арга хэмжээ авна.

43 дугаар зүйл
Дотоодын хянан шалгагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

43.1. Батлагдсан хуваарийн дагуу ээлжит, мөн гэнэтийн шалгалтыг салбар, нэгжүүдэд хийх;

43.2. Салбар, нэгжүүдэд нэвтрэн орох;

43.3. Салбар, нэгжүүдийн санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулах;

43.4. Шаардлагатай гэж үзсэн баримт материалын хуулбарыг салбар, нэгжүүдээс гаргуулан авах.

44 дүгээр зүйл

Банк нь санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр хөндлөнгийн аудиторыг сонгон ажиллуулж болно.

45 дугаар зүйл

Аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг ТУЗ тогтооно. Гэрээнд банкны болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн хэмжээг заана.

46 дугаар зүйл

Аудитор нь ТУЗ-ийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

47 дугаар зүйл

Банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийг аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно.

Зургаа. Банкнийг өөрчлөн байгуулах, татан буулгах

48 дугаар зүйл

Банкийг банкны хувь нийлүүлэгчийн шийдвэр, Монгол банкны зөвшөөрлөөр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

49 дүгээр зүйл

Өөрчлөн байгуулах, татан буулгах ажиллагааг Иргэний хууль, Банкны тухай болон Компанийн тухай хуулиудад заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

50 дугаар зүйл

Банкийг зөвхөн дараахь үндэслэлээр татан буулгаж болно:

50.1. Татан буулгахаар хувь нийлүүлэгч шийдвэрлэснийг Монгол банк хянан зөвшөөрсөн;

50.2. Банк төлбөрийн чадваргүй болсон учир албадан татан буулгах тухай Монгол банкны шийдвэр гарсан;

50.3. Банк байгуулах зөвшөөрлийг Монгол банк хүчингүй болгосон;

50.4. Дампуурлыг зарласан, хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөний учир банкнийг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон.

51 дүгээр зүйл

Татан буулгах ажиллагааг хувь нийлүүлэгчийн хурлын шийдвэрээр ТУЗ-өөс томилсон Татан буулгах комисс /цаашид "ТБК" гэх/, хэрэв бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буугдаж байгаа бол түүний томилсон комисс гүйцэтгэнэ.

52 дугаар зүйл

ТБК томилогдсон үеэс эхлэн банкны гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх ТБК-г шилжих ба татан буулгах ажиллагаа явагдаж байх хугацаанд ТБК нь банкнийг эрх зүйн харилцаанд төлөөлнө.

53 дүгээр зүйл

ТБК банкнийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухай нийтэд мэдээлсэнээс хойш 2 сараас багагүй 3 сараас ихгүй байна.

54 дүгээр зүйл

Банкийг татан буулгах үед түүний маргаангүй өр төлбөр /өглөг/-ийг холбогдох хуульд заасан даараллаар барагдуулна.

55 дугаар зүйл

Бүртгэх байгууллага банкнийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцох ба үүгээр банкны үйл ажиллагаа дуусгавар болно.

56 дугаар зүйл

ТБК нь нэхэмжлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэж байгаа эд хөрөнгийг хувь нийлүүлэгчийн мэдэлд шилжүүлнэ.

Долоо. Бусад зүйл

57 дугаар зүйл

Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

58 дугаар зүйл

Банк нь эд хөрөнгөө даатгуулж болно.

59 дүгээр зүйл

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Компанийн тухай хуульд заасан журмыг баримтална.

Засгийн газрын 2006 оны 165 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

“ХАДГАЛАМЖИЙН БАНК” ХХК-ИЙГ ХУВЬЧЛАХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЗАР МЭДЭЭ

Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”, Засгийн газрын 2006 оны 77 дугаар тогтоолоор баталсан “2006 онд эхний ээлжинд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалт”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 100 хувь төрийн өмчийн “Хадгаламжийн банк” ХХК /цаашид “Хадгаламжийн банк” буюу “банк” гэх/-ийг хувьчлах олон улсын нээлттэй, уралдаант шалгаруулалт /цаашид “тендер” гэх/-ыг Монгол Улсын Засгийн газар зарлаж байна.

Тендерийг Засгийн газрын 2006 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламжийн банк” ХХК-ийг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-ын журмын дагуу Төрийн өмчийн хороо зохион байгуулж дүгнэнэ.

Хадгаламжийн банкний худалдах доод үнэ 12.000.000.000 /арван хоёр тэрбум/ төгрөг болно.

Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх

Засгийн газраас тавьж буй дараахь шаардлагыг хангах хувийн өмчт дотоод, гадаадын болон олон улсын банк, санхүүгийн байгууллага, эсхүл тэдгээрийн оролцоотой байгуулсан консорциум /цаашид “этгээд” гэх/ тендерт оролцох сонирхлоо илэрхийлж болно:

-банк, санхүүгийн үйлчилгээний салбарт 5-аас доошгүй жил үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулсан;

-20.000.000 /хорин сая/ ам. доллараас доошгүй өөрийн хөрөнгөтэй;

-санхүүгийн байдал тогтвортой, үйл ажиллагааны баялаг туршлагатай.

Хэрэв консорциумаар оролцох тохиолдолд энэхүү шаардлагын 2 дахь хэсэгт заасан дүн нь консорциумын гишүүдийн өөрийн хөрөнгийн нийт дүнд тавигдах шаардлага бөгөөд харин консорциумын гишүүн банк, санхүүгийн байгууллагад 1 ба 3 дахь хэсэгт заасан шаардлага тавигдана.

Тендерийн зар мэдээ гарсны дараа тендерт оролцох сонирхлоо илэрхийлж буй этгээд /цаашид “өргөдөл гаргагч” гэх/ нь сонирхлоо илэрхийлсэн албан ёсны захидлыг монгол хэл дээр бэлтгэж, дараахь материалын хамт Төрийн өмчийн хороонд ирүүлнэ. Хэрэв гадаад хэл дээр бэлтгэсэн бол монгол орчуулгыг заавал хавсаргана:

1. Өргөдөл;

2. Өргөдөл гаргагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг зурсан нууцыг хадгалах тухай гэрээ;

3. Буцааж төлөгдөхгүй нөхцөлтэй 1.000 /нэг мянган/ ам. долларын тендерийн хураамж төлсний нотлох баримт;

4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсон тохиолдолд түүнд хуульд заасан журмын дагуу олгосон итгэмжлэл;

5. Өргөдөл гаргагчийн танилцуулга. Үүнд дараахь зүйлийг оруулсан байх шаардлагатай / консорциумаар оролцож байгаа тохиолдолд доорхи мэдээллийг консорциумын гишүүн тус бүрээр гаргана/:

-Өргөдөл гаргагчийн албан ёсны нэр, хаяг болон үйл ажиллагааны танилцуулга.

-Дотоод, гадаадын болон олон улсын банк, санхүүгийн үйлчилгээний салбарт ажиллаж, туршлага хуримтлуулсныг батлах мэдээлэл.

-Өргөдөл гаргагч /компани, хоршоо гэх мэт/-ийг үүсгэн байгуулж, бүртгүүлсэн тухай баримт бичгүүд.

-Сүүлийн жилийн эцсийн байдлаар гаргаж, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл /нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан жилийн тайлан/.

-Өргөдөл гаргагч нь хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компани бол нийт хувьцааны 5 /таvi/-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоо /компанийн эрх бүхий албан тушаалтан болон эрх бүхий байгууллага баталгаажуулсан байх шаардлагатай/.

-Тендерт консорциумын хэлбэрээр оролцох тохиолдолд консорциумын гишүүдийн хооронд байгуулсан гэрээ, консорциумаар оролцох тухай гишүүн бүрийн удирдах байгууллагын шийдвэр.

Тендерийн өргөдлийн маягт болон нууцыг хадгалах тухай гэрээний загварыг интернет дахь Төрийн өмчийн хорооны www.spc.gov.mn вэб хуудаснаас болон энэхүү зар мэдээний ард бичигдсэн хаягаар авч болно. Тендерийн хураамжийг энэхүү зар мэдээний ард бичигдсэн дансанд төлнө.

Өргөдөл гаргагч тендерт өөрийгөө төлөөлүүлэн оролцуулахаар итгэмжлэгдсэн төлөөлөгч томилбол түүний төлөөлөх эрхийг хуульд заасан журмын дагуу бичгээр үйлдсэн итгэмжлэлээр нотолно. Хэд хэдэн хуулийн этгээд, хувь хүн тендерт хамтран консорциумаар оролцож байгаа бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

Өргөдөл гаргагч өөрийн эрхэлж буй үйл ажиллагаа болон эрх зүйн байдал, хөрөнгө, санхүүгийн байдал, тендэрт ирүүлсэн бусад мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

Тендэрт оролцох сонирхлоо илэрхийлсэн өргөдлийг энэхүү зар гарсан өдрөөс эхлэн 2006 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө Төрийн өмчийн хороонд ирүүлнэ.

Урьдчилан шалгаруулалт

Тендэрт оролцох сонирхлоо илэрхийлсэн этгээд /өргөдөл гаргагч/-ийн өргөдөл нь Засгийн газраас тавьж буй шаардлагыг хангаж буй эсэхийг нягталж, Төрийн өмчийн хороо урьдчилан шалгаруулалт хийнэ. Урьдчилан шалгаруулалтыг өргөдөл хүлээж авах эцсийн өдөр буюу 2006 оны 9 дүгээр сарын 04-ний өдрөөс хойш ажлын 7 /долоон/ өдөрт багтаан хийнэ.

Урьдчилан шалгаруулалтын шатанд гадаадын хөрөнгө оруулагч нарын хувьд мөнгө угаахтай тэмцэх, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг болон авилгалын эсрэг хууль тогтоомжийн дагуу тавигдах шаардлагуудыг хэрхэн хангаж байгааг харгалзан үзнэ.

Засгийн газраас тавьж буй шаардлагыг хангаж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн өргөдөл гаргагч нь цаашид "тендэрт оролцогч" болж, тендерийн баримт бичгүүдийг авах эрхтэй болно. Энэ тухай мэдэгдлийг Төрийн өмчийн хороо бичгээр үйлдэн буухиа шуудан, баталгаат шуудан, факс буюу электрон шуудангийн аль боломжтойгоор нь өргөдөл гаргагчид хүргүүлнэ. Харин тендерийн баримт бичгүүдийг тендэрт оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид гардуулан өгнө.

Тендэрт оролцогчид тавих шаардлага

Тендерийн санал боловсруулах, ирүүлэхтэй холбогдуулан тендэрт оролцогчид дор дурдсан шаардлагыг тавина:

- эд хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх;
- мэргэжлийн чадавхитай боловсон хүчний хангамж, нөөцтэй байх;
- тендерийн саналыг зарласан нөхцөлийн хэмжээнд мэргэжлийн түвшинд хийсэн байх;
- мэргэжлийн дүгнэлт гаргуулсан байх /Шинжээчдийн баг гаргана/;
- тендерийн саналыг зарласан хугацаанд ирүүлсэн байх;
- дэнчингээ хугацаанд нь тавьсан байх;
- тендэрт оролцохтой холбогдсон бүх зардлыг өөрөө хариуцна.

Тендерийн баримт бичгүүд

1. Хадгаламжийн банкны тухай ерөнхий мэдээлэл.

2. Хадгаламжийн банкныг хувьчлах уралдаант шалгаруулалт /тендер/-ын журам;

3. Худалдах, худалдан авах тухай гэрээний төсөл.

Хувьчлалын зорилго

Хадгаламжийн банкныг худалдаж авах сонирхолтой тендэрт оролцогч нь Засгийн газраас дэвшүүлж буй дор дурдсан хувьчлалын зорилгыг хангах бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөөг боловсруулж, тендерийн саналтай хамт ирүүлэх шаардлагатай:

-Хадгаламжийн банкны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хадгалахын зэрэгцээ нийгэм, бүс нутгийн болон хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өргөтгөх, банк, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

-Хөрөнгө оруулж, банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, түүний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн чадавхийг сайжруулах, банкны зохистой практикт нийцсэн зээлийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх;

-Банкны болон санхүүгийн шинэ, дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэх.

Тендерийн ажиллагаа

Тендерийн саналаа бэлтгэхэд нь туслах зорилгоор тендэрт оролцогчдыг Төрийн өмчийн хороо, Монгол банк, Сангийн яамны зохих албан тушаалтан болон Хадгаламжийн банкны удирдлагатай уулзах, банк дээр нь очиж танилцах, дүн шинжилгээ хийх бололцоогоор хангана.

Тендэрт оролцогчид нь тендерийн санал ирүүлэхэдээ "Худалдах, худалдан авах гэрээ" байгуулж, хэрэгжүүлэх нотолгоо, худалдан авах үнийг төлөх санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон энэхүү зар мэдээний ард бичигдсэн дансанд урьдчилан 500.000 /таван зуун мянган/ ам.долларын хэмжээтэй дэнчин төлж, байршуулсан байна.

Тендерийн ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг худалдан авах үндэс оруулан тооцно. Харин тендерийн ялагчаар шалгараагүй оролцогчийн дэнчинг буцаан олгоно.

Тендэрт оролцогчид тендерийн саналаа тендерийн дэнчин төлснийг нотлох баримтын хамт Төрийн өмчийн хороонд 2006 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18.00 цагаас өмнө ирүүлнэ.

Тендерийн санал нь:

1/Техникийн санал

2/Санхүүгийн саналаас бүрдэнэ.

Техникийн санал нь Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хангах 2-оос доошгүй жилийн хугацааг хамарсан тендэрт оролцогчийн боловсруулсан бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөө ба тендерийн журамд заасан бусад материалаас бүрдэнэ.

Санхүүгийн санал нь Хадгаламжийн банкийг худалдан авахаар тендэрт оролцогчийн санал болгож буй үнэ, тендерийн журамд заасан бусад материалаас бүрдэнэ. Тендэрт оролцогчийн санал болгож буй үнэ нь Хадгаламжийн банкийг худалдах доод үнээс бага байж болохгүй.

Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна.

1. Техникийн саналын үнэлгээ
2. Санхүүгийн саналын үнэлгээ.

Техникийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдээр үнэлнэ:

1. Банк, санхүүгийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, нэр хүнд, бизнесийн ур чадвар (0-40 оноо);
2. Санал болгож буй бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-50 оноо);
3. Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэднийг гадаад, дотоодод сургах, дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх гэх мэтээр боловсон хүчнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалт, арга хэмжээг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан тендэрт оролцогчийн техникийн саналыг шалгаруулна. Техникийн саналын үнэлгээгээр шалгарсан тендэрт оролцогчдын санхүүгийн саналыг нээж үнэлнэ.

Санхүүгийн саналыг тендэрт оролцогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг байлцуулан тендерийн хуваарьт заасан өдөр нийтийн өмнө задална.

Санхүүгийн саналдаа хамгийн өндөр худалдан авах үнийн санал ирүүлсэн тендэрт оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулж, Төрийн өмчийн хороо Хадгаламжийн банкийг "Худалдах, худалдан авах гэрээ" байгуулна.

Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл

Хадгаламжийн банкийг Худалдах, худалдан авах гэрээнд эскроу гэрээ байгуулж, худалдан авах үнийг байршуулах, худалдан авах үнийг төлөх болон өмчлөгчийн эрх шилжүүлэх нөхцөл, хугацаа, худалдах, худалдан авах ажиллагааг дуусгавар болгох нөхцөл, худалдагч болон худалдан авагчийн хүлээх үүрэг, хариуцлага, мэдэгдэл, баталгаа болон бусад асуудал тусгагдана. Худалдах, худалдан авах гэрээний хугацаа 2 жил байна.

Тендерийн ялагч нь худалдан авсан үнийг Худалдах, худалдан авах гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор төлөх, тендэрт ялсан бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөөгөө 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Тендэрт оролцогчдыг тендерийн санал бэлтгэх явцдаа Худалдах, худалдан авах гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргах бололцоогоор хангана.

Хаяг, утас

Тендэрт оролцох сонирхлоо илэрхийлсэн өргөдлийг дараахь хаягаар ирүүлнэ:

Д.Сугар

Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IY байр, 410 тоот өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460, 261692
Факс: 976-11-312798

Тендэртэй холбогдолтой мэдээллийг www.spc.gov.mn вэбсайтаас, Бангтай холбогдолтой нэмэлт мэдээллийг www.savingsbank.mn гэсэн вэбсайтаас авна уу.

Дансны дугаар

Тендерийн хураамж болон дэнчинг Монгол Улсын "Монгол банк" дахь Төрийн өмчийн хорооны дараахь дансанд төлнө:

Банкны нэр:	Bank of Mongolia
SWIFT код:	BOCMUMNUB
Дансны нэр:	State Property Committee of Mongolia
Дансны дугаар:	3332404
Монголбанкны харилцагч банк:	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код:	FRNYUS33
Дансны нэр:	Bank of Mongolia
Дансны дугаар:	021088506

ХАДГАЛАМЖИЙН БАНКНЫ ТУХАЙ

Хадгаламжийн Банк нь банкуудын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 1996 онд байгуулагдсан бөгөөд 100% төрийн өмчийн банк юм. Анх үүсгэн байгуулагдахдаа иргэдийн мөнгөн хадгаламж, тэтгэвэр, тэтгэмж тавьж олгох, хэрэглэгчдийн орон сууц ашиглалтын төлбөр хураах зэрэг хязгаарлагдмал чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлж байсан бол эдүгээ банкны үйлчилгээний цар хүрээ, төрөл нэмэгдэж, арилжааны банкны бүхий л үйлчилгээг үзүүлж байна. Банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2006 оны 77 дугаар тогтоолыг үндэслэн Засгийн газрын 2006 оны 165 дугаар тогтоолоор тус банкныг "Хадгаламжийн банк" хязгаарлагдмал хармуцлагатай компани болгон зохион байгуулж, дүрмийг нь баталсан.

Хадгаламжийн банк нь 1996 оноос мөнгөн хадгаламжийн барьцаат зээл олгох, гадаад валют солих, иргэдийн үнэт зүйлс хадгалах үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд 1999 онд Дэлхийн хадгаламжийн банкуудын холбоо, 2001 онд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүн болсон бөгөөд арилжааны зээлийн эрх авч зээлийн хороо байгуулсан. 2002 онд гадаадын банкуудтай корреспондент харилцаа тогтоож, олон улсын банк хоорондын төлбөр тооцооны SWIFT байгууллагын гишүүнээр элсэн сүлжээнд холбогдсон бөгөөд мөн олон улсын мөнгөн гуйвуулгын Money Gram компанийн агент болсон. 2003 онд Visa International байгууллагын албан ёсны гишүүн болсон ба Азийн хөгжлийн банкны орон сууцны санхүүжилтийн төслийн зээлийг олгож эхэлсэн. Мөн ондоо онлайн систем, Вэбс программг нэвтрүүлж, 2005 оны 2 дугаар сараас нэгтгэн бодох бүртгэлийг уг программд бүрэн шилжүүлсэн байна.

Тус банк байгуулагдсан цагаасаа эхлэн нийгмийн даатгал болон халамжийн байгууллагууд нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудтай хамтран хотын иргэдийн ахуйн үйлчилгээний хэрэглээний бүхий л төлбөр болон 110 гаруй мянган иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрыг олгох үйлчилгээг дангаараа үзүүлж байна.

2006 оны байдлаар Улаанбаатар хотод төв банк, 1 салбар, тооцооны төв 32, хөдөө орон нутагт 7 салбар, 2 касс, нийт 42 салбар, нэгжүүдээрээ дамжуулан үйл ажиллагаа явуулж, гадаадын 5 банктай корреспондент харилцаа тогтоон гадаад, дотоодын банк, санхүүгийн зах зээлд харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Тус банкны Улаанбаатар хот дахь тооцооны төвүүдийн сүлжээний байршил, тоо хэмжээгээр бусад банкнаас илүү байгаа нь банкны гоц үйлчилгээг харилцагчиддаа хүргэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Тус банкинд 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 92.0 мянган иргэд, байгууллагын харилцах, хадгаламжийн дансанд 44,433.6 сая төгрөгийн эх үүсвэр байршиж байна. Үүнээс харилцах дансанд 8,900.7 сая төгрөг, хадгаламжийн дансанд 35,532.8 сая төгрөг байршиж байна.

Хадгаламжийн банк анх Засгийн газрын бондын хүүгээр дийлэнх орлогоо олдог байсан бол өнөөдөр үндсэн үйл ажиллагааны орлогын 91.5 хувийг зээлийн хүү болон худалдан авсан үнэт цааснаас олох хүүгийн орлого эзэлж байна. Тус банк 2005 онд нийт 8,849.0 сая төгрөгийн орлоготой ажилласан.

2005 онд тус банк нь 51.9 тэрбум төгрөгийн зээл олгож, 49.1 тэрбум төгрөгийн зээлийг төлүүлж, зээл олголт, төлөлтийн харьцаа 0.95:1 байж, 5.4 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн орлого олсон байна.

2006 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар Хадгаламжийн банк 50.5 мянган аж ахуйн нэгж, хувь хүнд нийт 30.99 тэрбум төгрөгийн зээл олгосон байгаагаас 29.5 тэрбум төгрөг буюу 95.2 хувь нь хэвийн, 565.3 сая төгрөг буюу 1.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 929.6 сая төгрөг буюу 3.0 хувь нь чанаргүй зээлийн ангилалд орсон бөгөөд зээлийн эрсдэлийн санг 805.8 сая төгрөгөөр байгуулсан.

2004 онд 8.2 тэрбум төгрөгийн банк хоорондын зээл болон хадгаламж байршуулж, бусад банкнаас 4.0 тэрбум төгрөгийн хадгаламж татаж байсан бол 2005 онд 15.9 тэрбум төгрөгийн банк хоорондын зээл болон хадгаламж байршуулж, бусад банкнаас 3.7 тэрбум төгрөгийн хадгаламж татаж ажилласан байна. Банк хоорондын зах зээл, хадгаламжийн хүүг тогтоох гол нөхцөл болох Төв банкны үнэт цаасны дундаж хүү 2004 онд 10.5 хувь, 2005 онд 5.5 хувь байжээ.

Тус банкны санхүү, бүртгэл, зээлийн үйл ажиллагаанд 2004 онд олон улсын аудитын "KPMG" компани, 2005 онд Монгол Улсын "Далайван аудит" компани тус тус хөндлөнгийн хяналт хийж санхүү, бүртгэлийн ажиллагааг олон улсын стандартын дагуу явагдсан гэж дүгнэсэн.

2005 оны аудитлагдсан тайлан балансаар нийт актив 57,218.59 сая төгрөг, өөрийн хөрөнгө 5,339.85 сая төгрөг, татварын дараахь цэвэр ашиг 573.65 сая төгрөг болжээ.

Арилжааны банкуудын дүрмийн сангийн доод хэмжээг 2006 оны 03 дугаар сарын 31-нээс 8.0 тэрбум төгрөг болгох Монгол банкны шийдвэрийг хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 41 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын хямдруулсан бонд гаргаж 3.5 тэрбум төгрөгөөр, Сангийн сайдын 2006 оны 75 дугаар тушаалын дагуу банкны цэвэр ашгаас хуваарилан 531.0 сая төгрөгөөр, нийт 4,031.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, банкны дүрмийн сан 8,031.0 сая төгрөг болсон. Энэ

талаар Монгол банкны Улсын байцаагч акт тогтоон баталгаажуулсан болно.

2006 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар:
 Нийт хөрөнгө: 52,860.7 сая төгрөг,
 Нийт зээл: 30,188.1 сая төгрөг,
 Зээлийн болзошгүй алдагдлын сан: 805.8 сая төгрөг,
 Мөнгөн хөрөнгө 15,324.2 сая төгрөг
 Богино хугацаат хөрөнгө

оруулалт: 2,886.0 сая төгрөг,
 Өөрийн хөрөнгө: 9,104.2 сая төгрөг,
 үүнээс : Дүрмийн сан: 8,031.0 сая төгрөг,
 Татварын өмнөх ашиг: 197.0 сая төгрөг,
 Нийт хөрөнгийн өгөөж: 0.37 %
 Өөрийн хөрөнгийн өгөөж: 2.16 % тус тус байна.

Монгол банкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийн биелэлт дараахь байдалтай байна. Үүнд:

Харьцаа	2006.03.31	2005	2004	2003
А	1	2	3	4
Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа 18% >	34.4	34.5	34.5	32.1
Зээлийн төвлөрлийн эрсдэл < 20%	10.98	14.64	14.6	17.3
Заавал байлгах нөөц	Хангасан	Хангасан	Хангасан	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ ≥ 10%	14.76	17.37	17.4	14.6

Хадгаламжийн банкны санхүүгийн сүүлийн 3 жилийн зарим үзүүлэлтүүдийг дор харуулбал:

АШИГ АЛДАГДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)				
Үзүүлэлт	2006.03.31	2005	2004	2003
А	1	2	3	4
Хүүгийн орлого	1661 672.80	7 389 696.70	7 912 972.00	7017593.18
Хүүгийн зардал	921 631.90	3 958 454.90	3 845 289.00	3826284.10
Хүүгийн цэвэр орлого	740 040.90	3 431 241.80	4 067 683.00	3191309.08
Эрсдлийн сангийн зардал	-166 403.40	591 612.80	588 266.00	147 305.37
Эрсдлийн сангийн дараахь хүүгийн цэвэр орлого	906 444.30	2 839 628.99	3 479 417.00	3044003.71
Хүүгийн бус орлого	225 597.70	1 459 263.60	1 613 197.00	1525243.37
Шимтгэл хураамжийн орлого	159 598.00	545 731.30	513 197.00	473 685.02
Валютын арилжаа, ханшийн тэгшитгэлийн орлого	28 389.70	140 997.80	974 400.00	1000231.07
Бусад	37 610.00	772 534.50	125 600.00	51 327.28
Хүүгийн бус зардал	935 041.00	3 725 243.80	3 975 046.00	3236740.92
Боловсон хүчний зардал	475 513.80	1 697 429.40	1 437 600.00	948 507.08
Валютын арилжаа, ханшийн тэгшитгэлийн зардал	39 822.80	142 318.30	937 700.00	936 841.93
Бусад	419 704.30	1 885 496.10	1 599 746.00	1351391.91
Нийт орлого	1887 270.50	8 848 960.30	9 526 169.00	8542836.55
Нийт зардал	1690 269.50	8 275 311.50	8 408 601.00	7210330.39
Татварын өмнөх ашиг	197 001.00	573 648.80	1 117 568.00	1332506.16
Татварын зардал	0.00	0.00	100 000.00	100 775.61
Цэвэр ашиг	197 001.00	573 648.80	1 017 568.00	1231730.55



Үлдэгдлийн тэнцэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2006.03.31	2005	2004	2003
A	1	2	3	4
ХӨРӨНГӨ				
Мөнгөн хөрөнгө	15324 242.80	16 755 777.00	15382918.40	8562453.64
Үнэт цаас /дэвэр/	2 886 016.30	11 007 508.40	17 140600.00	24955695.56
Монгол банкны	2 000 000.00	8 339 000.00	2 277 914.00	6166 000.00
Засгийн газрын	400 000.00	2 000 000.00	14 000000.00	16100 00.00
Бусад	486 016.30	668 508.40	862 686.00	2689 695.56
Зээл /дэвэр/	30188 154.80	25 190 478.20	21 168507.00	15374114.07
Хэвийн	29498 976.50	25 143 546.40	21 221463.00	15552409.86
Хугацаа хэтэрсэн	565 346.30	126 294.10	129 148.00	0.00
Чанаргүй	929 603.80	894 591.90	581 156.00	0.00
Хэвийн бус	206 649.50	283 363.00	39 345.00	0.00
Эргэлзээтэй	115 497.70	33 480.00	512 037.00	0.00
Муу	607 456.80	577 748.90	29 774.00	0.00
ЗТУБАХС	-805 772.00	-973 954.20	-763 260.00	-178 295.79
Үндсэн хөрөнгө	2 355 592.80	2 432 406.10	2 475 584.00	1363 712.73
ӨБҮХХөрөнгө	240 483.10	212 155.30	0.00	15 960.00
Бусад	1 866 196.60	1 850 619.00	731 981.00	800 654.97
Нийт хөрөнгө	52860 686.40	57 448 944.00	56 899 90.00	51072590.97
ӨР ТӨЛБӨР				
Харилцах	7 800 824.80	8 900 742.60	10 800369.00	8684 185.03
Хадгаламж	31944 193.60	35 532 850.90	34282 967.00	3549591.70
Хугацаагүй	5 709 371.80	5 904 838.90	7 344 473.00	7665 289.57
Хугацаатай	26234 821.80	29 628 012.00	26938 494.00	27830602.13
Бусад өр төлбөр	4 011 416.30	7 445 144.70	6 623 924.00	2877 621.02
Нийт өр төлбөр	43756 434.70	51 878 738.20	51 707260.00	47057697.75
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	9 104 251.70	5 570 205.80	5 192 330.00	4014 893.22
Дүрмийн сан	8 031 000.00	4 000 000.00	4 000 000.00	2608 401.44
Нөөцийн сангууд	859 451.90	795 072.00	174 762.00	174 761.23
Тухайн жилийн ашиг /алдагдал/	197 001.00	573 648.80	1 017 568.00	1231 730.55
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	16 798.80	201 485.00	0.00	0.00
Хоёрдогч өглөг	0.00	0.00	0.00	0.00
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	52860 686.40	57 448 944.00	56899 590.00	51072590.97

САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

(мянган төгрөг)*

Үзүүлэлт	2005 он	2004 он	2003 он
Хүүгийн цэвэр орлого	3 431 241.80	4 067 683.00	3 191 309.08
Хүүгийн бус орлого	1 459 263.60	1 613 197.00	1 525 243.37
Татварын өмнөх ашиг	573 648.80	1 117 568.00	1 332 506.16
Цэвэр ашиг	573 648.80	1 017 568.00	1 231 730.55
Нийт хөрөнгө	57 448944.00	56 899 590.00	51 072 590.97
Зээл, цэвэр дүнгээр	25190 478.20	21 168 507.00	15 374 114.07
Нийт өр төлбөр	51878 738.20	51 707 260.00	47 057 697.76
Хадгаламж	35532 850.90	34 282 967.00	35 495 891.70
Нийт өөрийн хөрөнгө	5 570 205.80	5 192 330.00	4 014 893.22

*Төгрөг/ам. долларын харьцаа (хугацааны эцэст)

1221

1103

1100

"ХАДГАЛАМЖИЙН БАНК" ХХК-ИЙГ ХУВЬЧЛАХ УРАЛДААНТ ШАЛГАРУУЛАЛТ /ТЕНДЕР/-ЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл", Засгийн газрын 2006 оны 77 дугаар тогтоолоор баталсан "2006 онд эхний ээлжинд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалт"-ыг хэрэгжүүлэх зорилгоор 100 хувь төрийн өмчийн "Хадгаламжийн банк" ХХК /цаашид "Хадгаламжийн банк" буюу "Банк" гэх/-ийг хувьчлах олон улсын нээлттэй, уралдаант шалгаруулалтыг зохион байгуулж явуулахад энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсанаар тодорхойлно:

2.1. "Банк" гэж Монгол Улсын "Хадгаламжийн банк" ХХК-ийг хэлнэ.

2.2. "Уралдаант шалгаруулалт /цаашид "тендер" гэх/" гэж "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 46-54 дүгээр зүйлийн дагуу төсөл сонгон шалгаруулалтыг зарлан дүгнэж /тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн саналуудыг үнэлж/, ялагчийг тодруулан түүнтэй "Худалдах, худалдан авах тухай гэрээ" байгуулах үйл ажиллагааг хэлнэ.

2.3. "Тендерт оролцогч" гэж Засгийн газраас тавьж буй шаардлагыг хангаж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн, энэ тухай Төрийн өмчийн хорооноос мэдэгдэл хүлээж авсан этгээдийг хэлнэ.

2.4. "Дэнчин" гэж "Худалдах, худалдан авах тухай гэрээ" байгуулж, хэрэгжүүлэх нотолгоо, худалдан авах үнийг төлөх санхүүгийн эх үүсвэрийн баталгаа болгон тендерт оролцогчоос Монгол банк дахь Төрийн өмчийн хорооны зохих дансанд байршуулах 500.000 /таван зуун мянган/ ам. доллартай тэнцүү хүүгүй мөнгөн хөрөнгийг хэлнэ.

2.5. "Тендерийн санал" гэж тендерт оролцогчоос тендерийн хуваарьт заасан хугацаанд хувьчлалын зорилгын шаардлагыг хангахуйцаар боловсруулж ирүүлсэн техникийн болон санхүүгийн саналын иж бүрдлийг хэлнэ. Тендерийн санал нь техникийн ба санхүүгийн санал, дэнчин төлсөн заримгаас бүрдсэн байдаг.

2.6. "Техникийн санал" гэж Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хангах 2-оос

доошгүй жилийн хугацааг хамарсан тендерт оролцогчийн боловсруулсан бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөө ба тендерийн журамд заасан бусад материалыг хайтдаг хэлнэ.

2.7. "Санхүүгийн санал" гэж банкнийг худалдан авахаар тендерт оролцогчийн санал болгож буй үнийг хэлнэ. Тендерт оролцогчийн санал болгож буй үнэ нь Хадгаламжийн банкний худалдах доод үнээс бага байж болохгүй.

2.8. "Худалдах, худалдан авах тухай гэрээний эхний төсөл" гэж тендерт оролцогчдын саналыг авахаар Төрийн өмчийн хорооноос санал болгон хүргүүлж буй худалдах, худалдан авах тухай гэрээний эхний төслийг хэлнэ.

2.9. "Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөл" гэж худалдах, худалдан авах тухай гэрээний эхний төсөлд тендерт оролцогчдоос ирүүлсэн саналуудаас тусгасан шинэчилсэн төслийг хэлнэ.

2.10. "Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл" гэж худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтөөс хүлээн авч болохуйц саналуудыг тусган Төрийн өмчийн хорооноос эцэслэн бэлтгэж гаргах төслийг хэлнэ.

2.11. "Шинэжээчдийн баг" гэж тендерийн саналд үнэлгээ хийх зорилгоор "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Төрийн өмчийн хорооны томилох шинэжээчдийг хэлнэ.

Гурав. Тендерийн хуваарь

3.1. Тендерийг энэхүү журамд хавсаргасан хуваарийн дагуу зохион байгуулж явуулна.

Дөрөв. Тендерт оролцогч

4.1. Тендерт оролцогчийн эрх зүйн байдал:

4.1.1. Тендерт оролцогч нь Засгийн газраас тавьж буй шаардлагыг хангаж, урьдчилан шалгаруулалтад тэнцсэн хувийн өмчит дотоод, гадаадын болон олон улсын банк, санхүүгийн байгууллага, эсхүл тэдгээрийн оролцоотой байгуулсан консорциум байна.

4.1.2. Хэд хэдэн хуулийн этгээд тендерт консорциумын хэлбэрээр оролцож байгаа

бол тэд зөвхөн нэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж, тендерт нэг оролцогч болж оролцоно.

4.2. Тендерт оролцогчид тавих хязгаарлалт:

4.2.1. Тендерийг албан ёсоор зарласнаас эхлэн тендерийн үйл ажиллагаа дуусах хүртэлх хугацаанд тендерт оролцогч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь бусад тендерт оролцох, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй энэхүү хувьчлалтай холбоотой асуудлаар аливаа хэлцэл хийх, харилцаа холбоо тогтоохыг хориглоно.

4.2.2. Тендерт оролцогч нь Төрийн өмчийн хороотой байгуулсан нууцыг хадгалах тухай гэрээний дагуу банктэй холбогдох мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

4.3. Тендерт оролцогчийн эрх:

4.3.1. Төрийн өмчийн хорооноос баталсан хуваарийн дагуу банктэй танилцах, дүн шинжилгээ, уулзалт хийх, банкны удирдлагатай уулзах, барилга байгууламжийг үзэх.

4.3.2. Төрийн өмчийн хорооны холбогдох албан тушаалтантай уулзах, мэдээлэл авах.

4.3.3. Энэхүү журам болон тендерийн үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн талаар тайлбар, тодруулга авах зорилгоор банкны хувьчлалыг хариуцсан Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй уулзах /тендерийн санал авах хугацаа дуусахаас ажлын 5-аас доош өдөрт ирүүлсэн тайлбар, тодруулга авах хүсэлтийг Төрийн өмчийн хороо хүлээж авахгүй байж болно/.

4.3.4. Тендерийн саналд үнэлгээ хийх Шинжээчдийн багийн гишүүн /шинжээч/-ийг хуульд заасан үндэслэлээр татгалзах, түүний үйл ажиллагааны талаар томилсон байгууллагад гомдол гаргах.

4.3.5. Тендерийн журам зөрчигдсөн гэж үзвэл гомдлоо Төрийн өмчийн хороонд түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гаргах.

4.3.6. Тендерт ялаагүй бол дэнчингээ буцаан авах.

4.3.7. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан бусад эрхийг эдлэх.

4.4. Тендерт оролцогчийн үүрэг:

4.4.1. Өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдлын талаар үнэн зөв мэдээлэл өгөх.

4.4.2. Тендерт оролцох явцад өөрийн бизнес, эрх зүй, санхүүгийн байдалд гарсан тендерт оролцоход нь нөлөөлж болзошгүй аливаа материаллаг өөрчлөлтийн талаар Төрийн өмчийн хороонд мэдэгдэх.

4.4.3. Банктэй байгуулсан буюу байгуулахаар төлөвлөж байгаа бизнесийн аливаа гэрээ, хэлэлцээрийн талаар Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэх.

4.4.4. Тендерт оролцох буюу оролцохтой холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах.

4.4.5. Тендерийн саналыг битүүмжилж Төрийн өмчийн хороонд өөрөө өгөх буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргүүлэх, хэрэв ийнхүү хүргэх боломжгүй бол баталгаат шуудангаар илгээж, зар мэдээнд заасан хугацаанд ирүүлэх.

4.4.6. Хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвар болон тендерт ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцах.

4.4.7. Өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх.

4.4.8. Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү журмыг сахин биелүүлэх.

4.4.9. Тендерт оролцогчийн зүгээс энэхүү тендерт оролцох бүхий л асуудлаар дотоодын аливаа зөрчилдөөн байхгүй талаар мэдэгдэх.

4.5. Тендерийн санал боловсруулах, түүнийг ирүүлэхтэй холбогдуулан тендерт оролцогчид тавих шаардлага:

4.5.1. Эд хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай байх.

4.5.2. Мэргэжлийн чадавхитай боловсон хүчний хангамж, нөөцтэй байх.

4.5.3. Тендерийн саналыг зарласан нөхцөлийн хэмжээнд, мэргэжлийн түвшинд хийсэн байх.

4.5.4. Мэргэжлийн дүгнэлт гаргуулсан байх /Шинжээчдийн баг гаргана/.

4.5.5. Тендерийн саналыг зарласан хугацаанд ирүүлсэн байх.

4.5.6. Дэнчингээ хугацаанд нь тавьсан байх.

Тав. Тендерийн баримт бичиг

5.1. Тендерт оролцогч тус бүрт Тендерийн журам, Ерөнхий мэдээлэл, "Худалдах, худалдан авах тухай гэрээ"-ний төслөөс бүрдсэн тендерийн баримт бичгийн нэг иж бүрэн багцыг олгоно.

5.2. Төрийн өмчийн хорооноос олгох тендерийн баримт бичигт Төрийн өмчийн хорооны тэмдэг дарсан байна.

5.3. Төрийн өмчийн хороо тендертэй холбоотой мэдээллийг тендерийн баримт бичигт оруулна. Энэхүү мэдээллийг зохих ёсоор ашиглаж чадаагүйтэй холбоотойгоор үүсч болох аливаа үүрэг, хариуцлагыг Төрийн өмчийн хороо хүлээхгүй.

Зургаа. Дүн шинжилгээ хийх

6.1. Тендерт оролцогчдыг тэдгээрийн хүсэлтийн дагуу Монгол банк, Сангийн яам, Төрийн өмчийн хорооны холбогдох албан тушаалтан болон

банкны удирдлагатай уулзах, газар дээр нь танилцах бололцоогоор хангана.

6.2. Тендерт оролцогчдыг тендерийн саналаа ирүүлэхээс нь өмнө банк дээр очиж банкны хөрөнгө, санхүүгийн чадавхи, өр төлбөрийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг Төрийн өмчийн хорооны холбогдох албан тушаалтантай хэлэлцэх, санал өгөх бололцоогоор хангана. Төрийн өмчийн хороо тендерт оролцогчдод банк дээр очиж банкны үйл ажиллагаанд нарийвчилсан дүн шинжилгээ хийхэд зориулж ойролцоогоор нэг долоо хоногоос доошгүй хугацаа олгоно. Дүн шинжилгээний хугацаанд тендерт оролцогчид банкны удирдлага, ажилтнуудтай уулзах өргөн боломжоор хангагдах бөгөөд санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнчлэн компьютерийн систем, конторын болон бусад барилга, байгууламжийн байдал болон өөрсдийн сонирхсон хүрээнд аливаа бусад асуудлыг судлах эрхээр хангагдана.

6.3. Төрийн өмчийн хороо нь банк дээр очиж дүн шинжилгээ хийх хуваарийг хүсэлт хүлээж авсан дарааллаар гаргаж, тендерт оролцогчдод энэ тухай факс буюу электрон шуудангаар мэдэгдэнэ.

6.4. Тендерт оролцогч нь тендерийн саналаа ирүүлснээр банкны байдал, үйл ажиллагааг судлан зөвшөөрч, эдгээр нөхцөл байдал болон Төрийн өмчийн хорооноос буюу түүний өмнөөс банкны талаар гаргаж өгсөн бүх мэдээллийн үнэн зөв болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Байгаа мэдээлэл, бодит байдалтай танилцаж чадаагүй тендерт оролцогч нь тендерийн санал боловсруулах, худалдах, худалдан авах тухай гэрээний төслийн талаар хэлэлцэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Төрийн өмчийн хороо банкны төлөөлөгчдөөс гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэн тендерт оролцогчийн гаргасан дүгнэлт, тайлбарын талаар Төрийн өмчийн хороо, шинэчлэлийн баг, банк, эдгээрийн төлөөлөгчдийн аль аль нь хариуцлага хүлээхгүй.

6.5. Тендерт оролцогч нь банктэй танилцаж, дүн шинжилгээ болон уулзалт хийхгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд ч тендерийн санал өгөх эрхтэй хэвээр байна.

Долоо. Худалдах, худалдан авах тухай гэрээний төслийг эцэслэн боловсруулах

7.1. Тендерт оролцогчдоос 2006 оны 09 дүгээр сарын 20-ны дотор ирүүлж санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо Худалдах, худалдан авах тухай гэрээний эхний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж болно.

7.2. Төрийн өмчийн хороо Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төслийг

боловсруулсан тохиолдолд энэ тухай тендерт оролцогч тус бүрт мэдэгдэж, шинэчилсэн төслийн хувийг 2006 оны 09 дүгээр сарын 27-ны дотор гаргаж хүргүүлэх.

7.3. Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа 2006 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс өмнө ирүүлэхийг тендерт оролцогчдод санал болгоно. Энэ өдрөөс хойш ирүүлсэн санал, тайлбарыг хүлээж авахгүй.

7.4. Худалдах, худалдан авах тухай гэрээний шинэчилсэн төсөлд оруулахаар тендерт оролцогчдоос санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүдийг харгалзан Төрийн өмчийн хороо Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг боловсруулж, тендерт оролцогч тус бүрт 2006 оны 10 дугаар сарын 13-ны дотор хүргүүлэх.

Найм. Тендерийн санал бэлтгэх, ирүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

8.1. Бүх мөнгөн дүнг АНУ-ын доллараар илэрхийлнэ.

8.2. Тендерт оролцогчид тендерийн саналыг монгол хэл дээр бэлтгэж ирүүлнэ. Хэрэв гадаад хэл дээр бэлтгэсэн бол монгол орчуулгыг заавал хавсаргана. Харин Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг монгол ба англи хэл тус бүр дээр ирүүлнэ.

8.3. Тендерт оролцогчид тендерийн саналын нэг эх хувь болон таван хуулбарыг ирүүлнэ.

8.4. Саналын эх хувь болон хуулбаруудын хооронд аливаа зөрүү гарах тохиолдолд эх хувийг баримтална.

8.5. Тендерт оролцогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендерийн саналын хуудас бүрт хар буюу хөх өнгийн бэхээр гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон эрхийг зохих журмын дагуу бичгээр гаргаж, тендерийн саналд хавсаргана.

8.6. Тендерийн саналд оруулсан бүх засварт тендерт оролцогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурж баталгаажуулсан байна.

8.7. Тендерийн саналыг шуудангаар ирүүлсэн тохиолдолд Төрийн өмчийн хороон дээр хүлээн авсан өдрийг тендерийн санал ирүүлсэн өдөр гэж тооцно.

8.8. Төрийн өмчийн хороо тендерийн саналыг хүлээж авсан огноо, цагийг тэмдэглэсэн баримтыг оролцогчид илгээж хүлээн авснаа

батална. Шуудангаар ирүүлсэн тендерийн саналд хариу илгээх факсын дугаарыг заагаагүй тохиолдолд хүлээн авсан тухай баримтыг ирүүлсэн саналын дугуйн дээрх хаягаар, эсхүл тендэрт оролцогчийн өргөдөлд заасан хаягаар илгээнэ.

8.9. Тендэрт оролцогч нь тендерийн санал хүлээн авах хугацаа дуусахаас өмнө Төрийн өмчийн хороонд бичгээр мэдэгдэж, тендерийн саналаа өөрчлөх, эсхүл татан авах эрхтэй.

Ес. Дэнчин

9.1. Тендэрт оролцогчид нь тендерийн саналаа ирүүлэхээс өмнө Монгол банкн дахь Төрийн өмчийн хорооны дор дурдсан валютын харилцах дансанд 500,000 /таван зуун мянган/ ам. долларын дэнчинг байршуулна. Үүнд:

Банкны нэр:	Bank of Mongolia
SWIFT код:	BOMUMNUB
Дансны нэр:	State Property Committee of Mongolia
Дансны дугаар:	3332404
Монгол банкны харилцагч банк:	Federal Reserve Bank of New York, NY, USA
SWIFT код:	FRNYUS33
Дансны нэр:	Bank of Mongolia
Дансны дугаар:	021088506

9.2. Дэнчин төлснийг нотолсон банкны баримтын хуулбарыг техникийн саналд хавсаргана.

9.3. Тендэрт оролцогч нь дэнчин тавиагүй тохиолдолд тендэрт оролцох эрхгүй.

9.4. Тендэрт ялагчаар шалгарсан оролцогчийн тавьсан дэнчинг худалдан авах үнэд оруулан тооцно.

9.5. Тендерийн саналыг үнэлсний дараа тендэрт оролцогч ялагчаар шалгараагүй тохиолдолд тендерийн дэнчинг тендэрт оролцогчийн хүсэлтийн дагуу ажлын долоон өдөрт багтаан бүрэн буцаан олгох бөгөөд хүсэлтэд дэнчинг шилжүүлэх банк, дансны дугаарыг тодорхой заана.

9.6. Дэнчинг дараахь тохиолдолд буцааж олгохгүй:

1) Ялагч нь санхүүгийн саналтайгаа хамт монгол, англи хэл дээр тус бүр хоёр хувь үйлдэж, хувь тус бүр дээр гарын үсэг зурсан Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийг ирүүлээгүй буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Тендерийн үр дүнгийн тухай мэдэгдэлд гарын үсэг зурахаас татгалзсан.

2) Ялагч нь Худалдах, худалдан авах тухай гэрээний нөхцөл, болзлын дагуу худалдан авах

үнийн төлбөрийг хийгээгүй буюу Худалдах, худалдан авах тухай гэрээнд заасан өөрийнхөө аливаа мэдэгдэл, баталгааг материаллаг байдлаар зөрчсөн.

9.7. Дэнчинд хүү төлөхгүй.

9.8. Дэнчин төлөхтэй холбогдсон банкны бүх зардлыг тендэрт оролцогч хариуцна.

Арав. Тендерийн саналд тавих шаардлага

10.1. Тендерийн санал дараахь хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 1) Техникийн санал
- 2) Санхүүгийн санал

10.2. Техникийн санал

Техникийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Тендэрт оролцогчийн талаархи мэдээлэл. Үүнд:

1) Тендэрт оролцогчийн бизнесийн үйл ажиллагааны чиглэл, компанийн бүтэц, арилжааны банк, санхүүгийн салбар дахь (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй компаниудын) үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга.

2) Сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэл (нээлтэй компанийн хувьд хувьцаа эзэмшигчдэд зориулсан сүүлийн 3 жилийн тайлан).

3) Тендэрт оролцогчоос санал болгож буй энэхүү тендэртэй холбогдолтой байж болох бусад нэмэлт мэдээлэл.

Б. Бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөө

Хадгаламжийн банкнийг худалдаж авах сонирхолтой тендэрт оролцогч нь Засгийн газраас дэвшүүлж буй дор дурдсан хувьчлалын зорилгыг хангах 2-оос доошгүй жилийн хугацааг хамарсан бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай. Үүнд:

-Хадгаламжийн банкны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хадгалахын зэрэгцээ нийгэм, бүс нутгийн болон хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлж өргөтгөх, банк, санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

-Хөрөнгө оруулж, банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, түүний төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн чадавхийг сайжруулах, банкны зохистой практикт нийцсэн эзэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх.

-Банкны болон санхүүгийн шинэ, дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэх.

Мөн бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөөнд Хадгаламжийн банкны ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэднийг гадаад, дотоодод сургах, дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх гэх мэтээр боловсон хүчнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалт, арга хэмжээг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж тусгах шаардлагатай.

В. Дэнчин төлснийг нотлох баримтыг техникийн саналын эх хувьд хавсаргана.

Г. Тендерийн энэхүү журмын сүүлчийн хуудсанд гарын үсэг зурсан хуулбарыг техникийн саналын эх хувьд хавсаргана. Тендерт оролцогч нь Тендерийн журамд гарын үсэг зурснаар энэхүү журмын заалтыг сахин мөрдөж, түүнд тусгасан бүх нөхцөл, болзлыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлнэ.

Д. Тендерт оролцохыг зөвшөөрч тендерт оролцогчийн удирдах байгууллагаас гаргасан шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас тендерт оролцохыг зөвшөөрч гаргасан шийдвэр).

10.3. Санхүүгийн санал

Санхүүгийн санал нь дор дурдсан хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

А. Хадгаламжийн банкныг худалдан авах үнэ. Энэ нь 12,000,000,000 /арван хоёр тэрбум/ төгрөгөөс доошгүй байна.

Б. Тендерт оролцогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хуудас бүр дээр гарын үсэг зурсан Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн монгол болон англи хэл дээрх тус бүр хоёр ижил эх хувь. Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төслийн гарын үсэг зурсан хоёр эх хувийг санхүүгийн саналын эх хувьд хавсаргасан байх шаардлагатай. Тендерийн ялагчаар бөглүүлэхээр зориуд хоосон үлдээсэн хэсгийг бөглөхөөс өөрөөр Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөлд өөрчлөлт оруулахыг үл зөвшөөрнө.

В. Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөлд гарын үсэг зурахыг зөвшөөрсөн тендерт оролцогчийн удирдах байгууллагын шийдвэр (консорциумаар оролцож байгаа тохиолдолд хамтарч буй хуулийн этгээд тус бүрийн удирдах байгууллагаас гарсан шийдвэр).

Г. Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон бол түүнд Худалдах, худалдан авах гэрээнд гарын үсэг зурах болон санхүүгийн саналыг нээх ажиллагаанд тендерт оролцогчийг төлөөлөх эрх олгосныг нотлох итгэмжлэл /Тендерт оролцогчийн өргөдөлд хавсаргасан итгэмжлэлд эдгээр эрхийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгосон тохиолдолд итгэмжлэлийн хувийг хавсаргана/.

Арван нэг. Тендерийн саналыг ирүүлэх

11.1. Техникийн болон санхүүгийн саналын эх хувь болон хуулбаруудыг "Эх хувь", "Хуулбар", "Техникийн санал" "Санхүүгийн санал" гэж тус тусад нь хаяглан битүүмжилж дугтуулна. Эдгээр дугтуйг хамтад нь өөр дугтуйд давхар хийж битүүмжилнэ. Гаднахь дугтуй дээр Төрийн өмчийн хорооны хаяг, тендерт оролцогчийн албан ёсны нэр, хаягийг бичиж:

"Монгол Улсын Хадгаламжийн банкныг худалдан авах тендерийн санал. Шинжээчдийн багийг байлцуулахгүйгээр нээхийг хориглоно" гэсэн тэмдэглэл хийнэ.

11.2. Тендерийн саналыг 2006 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн (Улаанбаатарын цагаар) 18⁰⁰ цагаас өмнө Төрийн өмчийн хороонд дараахь хаягаар ирүүлнэ:

Д. Сугар

Төрийн өмчийн хорооны дарга
Засгийн газрын IY байр, 410 тоот өрөө
Улаанбаатар-11, Монгол Улс
Утас: 976-11-312460, 261692
Факс: 976-11-312798

Арван хоёр. Тендерийн саналыг хүлээн авах

12.1. Тендерийн саналыг Төрийн өмчийн хорооны бичиг хэргийн бүртгэлээр дамжуулан банкны хувьчлалын асуудлыг хариуцсан Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээн авна.

12.2. Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тендерийн саналыг хүлээн авсан тухай тэмдэглэл үйлдэн, гарын үсэг, албан тэмдгээр баталгаажуулан тус тусад нь хадгална.

12.3. Тендерийн хуваарьт заасан хугацаанаас хойш тендерт оролцогчид тендерийн саналаа татан авах, саналд өөрчлөлт оруулахыг хориглох ба нэмж ирүүлсэн аливаа саналыг хүлээн авахгүй.

12.4. Тендерийн хуваарьт заасан тендерийн санал нээх өдөр Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч нь ирсэн бүх тендерийн саналыг тэмдэглэлийн хамт Шинжээчдийн багт хүлээлгэн өгнө. Энэ үед хэрэв хүсвэл тендерт оролцогчид, гэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид байж болно.

12.5. Шинжээчдийн баг тендерийн санал тус бүрийн бүрэн бүтэн байдлыг нь шалгаж хүлээн авах бөгөөд энэ тухай актад гарын үсэг зурна.

12.6. Шинжээчдийн баг тендерийн саналуудыг задалж, түүнд байгаа баримт бичиг нь энэхүү тендерийн журамд заасны дагуу бүрэн байгаа эсэхийг шалгана.

12.7. Хэрэв баримт бичиг дутуу байвал Шинжээчдийн баг энэ тухай тендэрт оролцогчид мэдэгдэж, тухайн үзүүлэлтээр үнэлгээ өгөхгүй байх, эсхүл бууруулах, тендерийн саналыг шалгаруулалтаас хасаж буцаах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Арван гурав. Тендерийн саналын үнэлгээ

13.1. Төрийн өмчийн хороо тендерийн саналыг үнэлүүлэх зорилгоор Шинжээчдийн багийг төсөл шалгаруулах өдөр томилно.

13.2. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа нь дараахь хоёр үе шаттай байна. Үүнд:

- 1) Техникийн саналын үнэлгээ
- 2) Санхүүгийн саналын үнэлгээ

13.3. Шинжээчдийн баг нь техникийн саналыг дор дурдсан үзүүлэлтүүдийг үндэслэн онооны системээр үнэлнэ. Үүнд:

1) Тухайн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн туршлага, санхүүгийн чадавхи, нэр хүнд, бизнесийн ур чадвар (0-40 оноо)

2) Санал болгож буй бизнесийн стратеги (үйл ажиллагааны) төлөвлөгөөний чанар, Засгийн газраас дэвшүүлж буй хувьчлалын зорилгыг хүлээн авч тусгасан байдал (0-50 оноо)

3) Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэднийг гадаад, дотоодод сургах, дадлагажуулах, өргөшлийг нь дээшлүүлэх гэх мэтээр боловсон хүчнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалт, арга хэмжээг тусгасан хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө (0-10 оноо).

13.4. Нийлбэр дүнгээр 70-аас доошгүй оноо авсан техникийн саналыг шалгаруулна.

13.5. Техникийн саналын үнэлгээ дууссаны дараа Шинжээчдийн баг техникийн санал нь тэнцсэн оролцогчдод техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангасан тухай болон санхүүгийн саналыг нээхээр төвлөсөн газар, огноо, цагийг мэдэгдэнэ. Үүний зэрэгцээ техникийн саналын үнэлгээгээр авбал зохих доод онооны болзлыг хангаагүй оролцогчдод энэ тухай болон дэнчинг буцаан олгох тухай мэдэгдэнэ. Мэдэгдлийг буухиа шуудан, факс буюу электрон шуудангаар явуулж болно.

13.6. Техникийн саналын үнэлгээгээр тэнцсэн тендэрт оролцогчдын санхүүгийн саналыг тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг

байлцуулан нийтийн өмнө тендерийн хуваарьт заасан өдөр задална.

13.7. Тендэрт оролцогчийн нэр болон Хадгаламжийн банкныг худалдан авахаар санал болгож буй худалдан авах үнийг чангаар уншиж, бүртгэнэ. Шинжээчдийн баг санхүүгийн саналд зохих ёсоор гарын үсэг зурсан Худалдах, худалдан авах тухай гэрээний эцсийн төсөл болон энэхүү журмын 10.3-т заасан баримтыг хавсаргасан эсэхийг шалгах ба санхүүгийн саналуудыг нийтийн өмнө задлах ажиллагааны тэмдэглэл хөтөлнө.

13.8. Санхүүгийн саналдаа хамгийн өндөр худалдан авах үнийн санал ирүүлсэн тендэрт оролцогчийг тендерийн ялагчаар шалгаруулна.

13.9. Тендэрт оролцогчид ижил үнийн санал ирүүлсэн тохиолдолд тэдгээрийг техникийн саналын үнэлгээгээр авсан онооны дагуу эрэмбэлж, илүү оноо авсан нь тендерийн ялагч болно. Хэрэв техникийн саналын үнэлгээгээр авсан оноо нь тэнцэж байвал худалдан авах үнийн шинэ саналыг нэг цагийн дотор бичгээр өгөх боломж олгоно. Энэ ажиллагааг аль нэг оролцогч бусдаасаа илүү өндөр үнийн санал ирүүлэх хүртэл үргэлжлүүлэн явуулна.

13.10. Тендерийн саналыг үнэлэх үйл ажиллагаа дууссаны дараа Шинжээчдийн баг тендерийн үнэлгээний тайлан, дүгнэлтээ Төрийн өмчийн хорооны хуралдаанд оруулан хэлэлцүүлнэ.

13.11. Төрийн өмчийн хорооны хуралдаанаас үнэлгээний тайлан, дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзвэл батлах, үндэслэлгүй болон хууль зөрчсөн гэж үзвэл дахин үнэлгээ, шинжилгээ хийлгэх шийдвэрийн аль нэгийг гаргана.

13.12. Төрийн өмчийн хорооны хуралдаанаас үнэлгээний тайланг үндэслэлтэй гэж үзэн баталсан тохиолдолд Төрийн өмчийн хороо Худалдах, худалдан авах тухай гэрээнд гарын үсэг зурна.

Арван дөрөв. Тендерийг явагдаагүйд болон хүчингүйд тооцох, санал ирүүлэх хугацааг сунгах

14.1. Төрийн өмчийн хороо тендерийн санал ирүүлэх эцсийн өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнөх хугацаанд энэхүү тендерийн журамд хуульд харшлахгүй нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

14.2. Төрийн өмчийн хороо тендерийн санал ирүүлэх хугацаа, тендерийн хуваарийг өөрийн санаачилгаар болон тендэрт оролцогчийн хүсэлтийн дагуу сунгах буюу өөрчилж болно. Тендерийн журам, хуваарьт оруулсан аливаа өөрчлөлтийн



талаар Төрийн өмчийн хороо бүх оролцогчдоод бичгээр мэдэгдэнэ.

холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

14.3. Тендерт оролцогчдоос нэг нь ч тендерийн санал ирүүлээгүй тохиолдолд тендерийг явагдаагүйд тооцох ба энэ тухай шийдвэрийг Төрийн өмчийн хороо гаргана.

15.2. Гомдол, маргаан гаргагч нь Төрийн өмчийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл зохих шатны шүүхэд хандаж болно.

14.4. Тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн саналын техникийн саналууд нь бүгд 70-аас доош оноо авсан, эсхүл хуульд заасан бусад үндэслэлээр тендерийг хүчингүйд тооцох ба энэ тухай шийдвэрийг Төрийн өмчийн хороо гаргана.

Энэхүү журмыг хүлээн зөвшөөрсөн тендерт оролцогчийн гарын үсэг

_____ /_____ /

Арван тав. Маргаан шийдвэрлэх

/гарын үсэг/ /нэр/

15.1. Тендертэй холбоотой гарсан аливаа гомдол, маргааныг Төрийн өмчийн хороо

Он, сар, өдөр _____

Тендерийн журмын хэвсрэлт

ТЕНДЕРИЙН ХУВААРЬ

Үйл ажиллагаа	Огноо/Эцсийн хугацаа
Тендерийн зар мэдээ	2006-07-08
Тендерт оролцох сонирхлоо илэрхийлэх өргөдлийг хүлээн авах	2006-09-04
Тендерт оролцох өргөдөл гаргагчид урьдчилан шалгаруулалт хийх, Тендерийн баримт бичгийг хүргүүлэх	2006-09-05-наас 2006-09-12
Банк дээр дүн шинжилгээ хийх, банктэй танилцах, тендерийн саналаа бэлтгэх	2006-09-13-наас 2006-10-13
Худалдах, худалдан авах гэрээний төслийн талаар санал авах	2006-09-20
Худалдах, худалдан авах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулан гаргаж хүргүүлэх	2006-09-27
Худалдах, худалдан авах гэрээний шинэчилсэн төслийн талаар санал авах	2006-10-04
Худалдах, худалдан авах гэрээний эцсийн төслийг бэлтгэж хүргүүлэх	2006-10-13
Тендерийн санал ирүүлэх	2006-10-25
Техникийн саналыг үнэлэх	2006-10-26-наас 2006-11-01
Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж үнэлэх/Тендерийн үр дүнг нийтэд мэдээлэх	2006-11-02
Гэрээнд гарын үсэг зурах	2006-11-02

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зорчсон эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан, Л.Рэнчин, П.Очирбат, Ж.Амарсанаа, Ч.Дашням,

Д.Наранчимэг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантунаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд хүсэлт гаргагч Улсын Дээд шүүхийг төлөөлж Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч А.Доржготов, мөн Улсын Ерөнхий прокурорыг төлөөлж Улсын Ерөнхий прокурорын туслах, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Л.Болд, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлын Сонгуулийн хууль батлагдсантай холбогдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцжэ байгаа эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 1/636 дугаар албан бичгээр гаргасан хүсэлтдээ:

"...Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 178 дугаар зүйлийн 178.1-д "...хэрэг бүртгэх ажиллагааг хөнгөн гэмт хэрэгт 14 хоног, хүндэвтэр гэмт хэрэгт 30 хоногт явуулна..." гэж заасан атал Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай хуулиар уг хуулийн 178 дугаар зүйлд "Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан хөнгөн гэмт хэргийн хэрэг бүртгэх ажиллагааг 4 хоног, хүндэвтэр гэмт хэргийн хэрэг бүртгэх ажиллагааг 7 хоногт багтаан явуулна" гэсэн 4 дэх хэсэг нэмсэн нь байцаан шийтгэх ажиллагааны оролцогч нарын хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарласнаас гадна хэрэг бүртгэлт явуулах үндсэн хугацаатай нийцээгүй байна.

Өөрөөр хэлбэл, хөнгөн буюу хүндэвтэр ангилалд хамаарах гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч нь хэрэг шалгах хугацааны дотор эрх, үүргээ хэрэгжүүлэх ижил нөхцөл, боломжтой байх эрхийг боогдуулж алагчлан ялгавартай тогтоосон шинэктэй болжээ.

Нийт хөнгөн, хүндэвтэр хэргүүдээс тусад нь зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 130 дугаар зүйлд заасан "Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх", 131 дүгээр зүйлд заасан "Сонгуулийн болон

бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах" гэмт хэргийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг хэт багасгаж бууруулснаар Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчөөд зогсохгүй хэргийн байдлыг тал бүрээс нь бодитойгоор тогтоож шийдвэрлэх боломжгүй гэж үзэж байна" гэжээ.

Хоёр. Улсын дээд шүүхээс 2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1/1097 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан хүсэлтдээ:

"1. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт буюу уг хуулийн 225 дугаар зүйлийн 225.5, 233 дугаар зүйлийн 233.2, 302 дугаар зүйлийн 302.4, 304 дүгээр зүйлийн 304.4, 309 дүгээр зүйлийн 309.4, 346 дугаар зүйлийн 346.4-т Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар хэрэг бүртгэлт явуулах, уг хэргийн яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх, шүүхийн шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргах хугацааг хэт багасган тогтоосон нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "...нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тодорхой зүйл, заалтад шинээр оруулсан нэмэлтийг ижил төрлийн харилцааг зохицуулж буй мөн зүйлийн тухайн зүйл хэсэгтэй харьцуулан үзвэл жишээ нь, бусдад эд зүйлээ дээрэмдүүлсэн хэргийн хохирогч "А"-гийн гомдлоор эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 309 дүгээр зүйлийн 309.1-д зааснаар давж заалдах шатны шүүх 30 хоногийн дотор, харин сонгогдох эрх нь зөрчигдсөн гэх хэргийн хохирогч буюу нэр дэвшигч, эсвэл Сонгуулийн хорооны гишүүний гомдлоор "Б"-гийн хэргийг шинээр оруулсан нэмэлт буюу Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 309 дүгээр зүйлийн 309.4-д зааснаар давж заалдах шатны шүүх 5 хоногийн дотор хэлэлцэх журамтай болжээ.

Ийнхүү Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан дээрх нэмэлтүүд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн

бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэнтэй зөрчилдөж байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлтийн дагуу тухайлбал, хэрэг бүртгэгч хөнгөн гэмт хэрэг бүртгэлтийг 4 хоногт багтаан явуулах ба харин анхан шатны шүүх уг хэргийг яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарсан өдрөөс эхлэн 3 хоногоос хэтрүүлэхгүйгээр шүүх хуралдаанаар хэлэлцэх болсон нь Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн өмгөөлөгч нотлох баримт шалгуулах хүсэлтээ гаргах боломжийг хязгаарлаж байгаагаас гадна эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдоос ийм хүсэлт гаргасан тохиолдолд ч хэрэг бүртгэгч болон шүүх цаг хугацааны хувьд уг хүсэлтийг хүлээн авч хангаж чадахгүйд хүргэж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлтийн дагуу Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт явуулах, шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх маш богино, хязгаарлагдмал хугацааг тогтоосон нь хэргийн бодит үнэнийг тогтоох гэсэн зарчмыг хэрэг бүртгэлт хийгээд шүүхийн үйл ажиллагаанаас ангид байлгаж, улмаар тухайн иргэн шударга шүүхээр шүүллэх эрхээ бодитой эдлэх боломжийг хязгаарлах нөхцөлийг бий болгож байна.

Ийм учраас Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан дээрх нэмэлтүүд нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "... нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүллэх ... эрхтэй" гэсэн заалтыг зөрчиж байна.

Гурав. Улсын дээд шүүхээс 2006 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 1/1168 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан хүсэлтдээ:

"1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлд "Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай шүүгчийн шийтгэврийн талаарх болон сонгуулийн холбогдолтой хэрэгт давж заалдсан гомдлыг шүүх хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан шийдвэрлэнэ" гэсэн нэмэлтийг уг зүйлийн 7 дугаар хэсэг болгон оруулжээ.

Захиргааны хариуцлага хүлээлгэх тухай анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрт гомдол

гаргах журам нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлүүдэд тусгагдсан ба шүүгчийн шийтгэвэрт 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргахаар зохицуулагдсан байдаг. Энэ гомдлыг нь тухайн шатны шүүх 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж, тогтоол гаргах ба уг тогтоол нь эцсийн шийдвэр байхаар заасан байна. Үүнээс гадна, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т "энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ" гэж заажээ. Түүнчлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 161 дүгээр зүйлд давж заалдах шатны шүүхээр хэлэлцэгдэх гомдлын хүрээ хязгаарыг тодорхойлохдоо "анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрт ... давж заалдах гомдол гаргах" -аар тусгасан бөгөөд аймаг, Нийслэлийн давж заалдах шатны шүүхүүд захиргааны хариуцлага хүлээлгэсэн анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэврийг давж заалдах журмаар хянадаггүй билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлд орсон дээрх нэмэлт сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдийн зөрчилд захиргааны шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэврийг хянах журмыг бусад төрлийн захиргааны зөрчлийн талаар гарсан шийтгэврийг хянах журмаас өөрөөр тогтоосон ба энэ нь шүүгчийн шийтгэврийг хянах шүүхийн тогтолцоог эвдэж, мөн хуулийн бусад зүйл, заалттай зөрчилдөж байгаагаас гадна Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

Захиргааны зөрчил гаргаж, шүүгчийн шийтгэвэр шийтгэл хүлээсэн аливаа этгээдийн гомдлыг анхан шатны шүүх хэлэлцдэг байхад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн гомдлыг аймаг, нийслэлийн шүүх хэлэлцэх ямар үндэслэл байгаа нь ойлгомжгүй болжээ. Сонгуулийн хууль тогтоомжийн зөрчлийг бусад хуулийн зөрчлөөс илүү чухал гэж үзэх, эсхүл тухайн зөрчил гаргагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч буюу түүнийг дэмжигч тул бусад зөрчил гаргагчдаас илүү ич холбогдолтой гэж үзэх нь "хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... үзэл бодлоор нь ... ялгарваран гадуурхаж үл болно"



гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмыг хөндөж байна гэж Улсын Дээд шүүх үзнэ.

Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн тухай шүүгчийн шийтгэвэрт гарсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171, 161, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т заасан зохицуулалтыг баримталж, анхан шатны шүүх хэлэлцэх, эсхүл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.7-д заасны дагуу давж заалдах шатны шүүх хэлэлцэх нь ойлгомжгүй байгаагаас Үндсэн хуулийн Дечин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "шүүгч ...гагцхүү хуульд захирагдана" гэсэн зарчмыг шүүх бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломжгүй болж байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлд "сонгуулийн холбогдолтой хэргийг хяналтын шатны шүүх хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ" гэсэн нэмэлтийг 2 дахь хэсэг болгон оруулжээ.

Хяналтын шатны шүүх нь өөрийн эрх хэмжээний хүрээнд иргэний хэргийг 30 хоногийн дотор хянахаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1-д заажээ.

7 хоног гэдэг нь 30 хоногт багтах хугацаа хэдий ч хяналтын журмаар х... хянан шийдвэрлэх хугацааны дээд хязгаарыг зөвхөн сонгуулийн холбогдолтой хэрэг маргаанд доошлуулж тогтоосноор тухайн хэргийн оролцогчдын эрх, шүүхээс хэргийг ул үндэстэй шийдвэрлэх боломжид муугаар нөлөөлөөд зогсохгүй утгаа "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн Үндсэн хуулийн зарчмыг зөрчсөн гэж үзэж байна.

Нөгөө талаар, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим хугацаатай харьцуулж үзвэл иргэний бүх төрлийн хэргийг давж заалдах журмаар 30 хоног, хяналтын журмаар 30 хоногийн дотор хянан хэлэлцэхээр тогтоосон байхад сонгуулийн холбогдолтой хэргийг 7 хоногт хянан шийдвэрлэх нь хэтэрхий бага хугацаа гэдэг нь ойлгогдоно. Түүнчлэн хэргийн оролцогч шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш давж заалдах гомдлыг 14 хоногийн дотор, хяналтын гомдлыг 30 хоногийн дотор гаргадаг байхад хяналтын шатны шүүх /давж заалдах шатны шүүх ч мөн адил/

хэргийн оролцогчийн гомдол бичих хугацаанаас даруй 2-4 дахин богино хугацаанд хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй болж байна.

Сонгуулийн холбогдолтой хэрэг маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх шаардлага нь сонгуулийн өөрийн хугацаатай холбоотой болох нь ойлгомжтой ч хугацааны энэхүү шахуу байдлыг шүүх өөрийн ажлын дотоод зохион байгуулалтаар хянан тохируулах боломжтой байхад хэргийн оролцогчдын хуульд заасан эрхийг хязгаарласан нь процессын хуулийн нэгдмэл агуулгыг ч алдагдуулж, Үндсэн хуулийн зарчмыг ч зөрчсөн гэж үзэхээр байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т "сонгуулийн холбогдолтой хэргийг" гэж заасан хэдий ч хуулийн 166 дугаар зүйлийн 166.7-д сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэсэн шүүгчийн шийтгэврийг давж заалдах шатны шүүх хянахаар туссан ба давж заалдах шатны шүүхийн магадлалд мөн хуулийн 167 дугаар зүйлийн 167.5-д зааснаар хяналтын шатны шүүхэд гомдол гаргах боломжтой тул захиргааны шийтгэл хүлээлгэсэн шүүгчийн шийтгэврийг хяналтын шатны шүүх хянах үүрэгтэй болж байна.

Энэ утгаараа хяналтын шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.7, 167 дугаар зүйлийн 167.5, 174 дүгээр зүйлийн 174.2-т заасныг баримталвал захиргааны шийтгэл ноогдуулсан шийтгэврийг хянаж, мөн хуулийн 170, 171 дүгээр зүйл, 172 дугаар зүйлийн 172.1-ийг баримталбал шийтгэврийг хянахгүй байхаар болжээ.

Уг тохиолдолд нэг асуудлыг хоёр өөрөөр зохицуулсан адилхан хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зүйл, заалтын нэгийг нь баримталж, нөгөөг нь зайлшгүй зөрчих тул шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагаа мухардалд орж, "...шүүгч гагцхүү хуульд захирагдана" гэсэн Үндсэн хуулийн шаардлага хэрэгжих боломжгүй болно" гэжээ.

Дөрөв. Улсын дээд шүүхээс 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1127 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан хүсэлтдээ:

"1.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлд "11.6.Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шалгах

ажиллагааг шүүгч 7 хоногт багтаан явуулна” гэсэн нэмэлт оруулжээ.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар захиргааны зөрчлийг эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн, зөрчлийг хянан шалгах ажиллагааг 14 хоногийн дотор явуулах, энэ хугацаанд дуусгах боломжгүй бол тухайн эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр 14 хоногоор сунгаж, зөрчлийн тухай тэмдэглэл хөтлөх, үзлэг шинжилгээ хийх, шаардлагатай эд зүйл, баримт бичгийг түр хураах, зөрчил гаргасан этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, албадан саатуулах зэрэг цогц ажиллагаанууд хийгдэх ёстой билээ.

Гэтэл сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг шүүгч өөрөө 7 хоногийн дотор хянан шалгаж, нотлох баримтыг өөрөө цуглуулж, зөрчил гаргасан этгээдэд арга хэмжээ авах эсэхээ шийдвэрлэхээр болж байгаа нь талуудын тэгш эрхийн зарчмыг алдагдуулж байгаа төдийгүй, захиргааны зөрчил гаргасан этгээдийн зөрчлийг хянан шалгах хугацааг 2 өөрөөр хуульчилж, тухайн хуульд заасан боломжит хугацааг хэт багасгаснаар захиргааны зөрчил гаргасан этгээдийн эрхээ хамгаалуулах боломжийг алдагдуулж байна.

Энэ нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн заалттай зөрчилдөж байгаагаас гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзнэ.

2. Мөн хуулийн "Захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах, гомдол гаргах" гэсэн 19 дүгээр зүйлд "19.8. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн шийтгэвэрт 3 хоногийн дотор гомдол гаргаж болох ба давж заалдах гомдлыг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар бүлэгт заасны дагуу хянан шийдвэрлэнэ" гэсэн нэмэлт оруулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч нар захиргааны шийтгэл ногдуулсан шийтгэврийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор дээд шатны шүүхэд давж заалдах гомдол гаргаж, хууль тогтоомжийг өөрөөр заагаагүй бол давж заалдах гомдлыг эрх бүхий албан тушаалтан хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор хянан

шийдвэрлэхээр Захиргааны хариуцлагын тухай хуульд заажээ.

Гэтэл захиргааны зөрчил гаргасан этгээдэд шийтгэл ногдуулсан анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргах журам нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлүүдийн дагуу зохицуулагдсан ба шүүгчийн шийтгэвэрт 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргахаар өөрөө заагджээ.

Энэ заалт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн "Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дунд, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ" гэсэн заалттай нийцэж байхад сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн шийтгэвэрт 3 хоногийн дотор гомдол гаргаж болохоор хуульчлан зааж, гомдол гаргах хугацааг багасгаж, бусад захиргааны зөрчилд шийтгэл ногдуулсан шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргаж болох хуульд заасан хугацаанаас өөрөөр тогтоосон нь дээрх хуулийн заалтуудтай зөрчилдөж байгаагаас гадна Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Дочин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "шүүгч ...гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн захиргааны зөрчилтэй хэргийн оролцогчдоос захиргааны зөрчилд шийтгэл ногдуулсан анхан шатны шүүхийн шүүгчийн шийтгэвэрт гомдол гаргахдаа дээд шатны шүүхэд нь гомдол гаргах Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа өнөөгийн нөхцөлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.7 дахь хэсгийн дагуу давж заалдах шатны шүүх гомдлыг үндэслэн шийтгэврийг хянахаар байгаа нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 57 дугаар зүйлийн 57.2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170, 171 дүгээр зүйлийн заалтуудтай зөрчилдсөн, аль хууль нь Үндсэн хуульд нийцэж байгааг тодорхойлох боломжгүй, дээрх хуулиудад нэ үйл баримтыг хоёр өөрөөр зохицуулсан зэрэг нь "шүүгч ...гагцхүү хуульд захирагдана" гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг шүүн

таслах ажиллагаанд хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа юм.

Иймд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү" гэжээ.

Тав. Улсын Их Хурлын иргэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 5 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн тайлбартаа:

"Улсын Их Хурал 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулиар Улсын Их Хурлын сонгуулийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө зарлахаар хуульчилж, сонгуулийн үйл ажиллагааны үе шатны ажлуудын хугацааг богиносгон тогтоосонтой холбогдуулж, Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт хэрэг бүртгэх ажиллагаа явуулах, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шүүхийн шийдвэрийн хувийг холбогдох этгээдэд гардуулах, давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргах, хяналтын журмаар уг хэргийг хянан шийдвэрлэх, түүнчлэн сонгуультай холбогдсон иргэний хэргийг давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэхтэй холбогдсон хугацааг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндсэн хугацаанаас багаар тусгайлан тогтоосон өөрчлөлтийг эдгээр хуульд оруулсан. Түүнчлэн Захиргааны хариуцлагын тухай хуульд ч дээрхтэй адил өөрчлөлт оруулсан.

Сонгуультай холбоотой маргаан сонгуулийн хугацаанд шийдвэрлэгдэхгүй байх явдал өмнөх сонгуулийн үед гарч байсан тул сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбоотой асуудлыг сонгууль зохион байгуулах хугацаанд шийдвэрлэж байх шаардлагын үүднээс ийнхүү тогтоосон бөгөөд энэ нь сонгуулийн холбогдолтой хэрэг, маргааны шалган шийдвэрлэхэд богино хугацаа тогтоосноор асуудлыг тухайн цаг үед нь хянан шийдвэрлэх замаар оролцогчдын эрхийг ханган баталгаажуулах боломж бүрдүүлнэ гэж хууль тогтоогч үзсэн юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуультай холбогдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан

шийдвэрлэх тухай, Захиргааны хариуцлагын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна" гэжээ.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар дүгнэлтдээ:

"1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл /Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 178.4; 225.5; 233.2; 302.4; 304.4; 309.4; 346.4 дэх хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 166.7; 174.2 дахь хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг /Захиргааны хариуцлагын тухай хуульд 11.6; 19.8 дахь заалт нэмсэн/ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээр дурдсан хуулийн холбогдох заалтууд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2; Арван зургадугаар зүйлийн 14; Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй байна" гэж үзэжээ.

Долоо. Улсын Их Хурал 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолдоо:

"Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 178.4, 225.5, 233.2, 302.4, 304.4, 309.4, 346.4 дэх хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166.7, 174.2 дахь хэсэг, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11.6, 19.8 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан

шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Хэрэг бүртгэх ажиллагааг явуулах, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхлэх, шийтгэх ба цагаатгах тогтоолын хуулбарыг гардуулан өгөх, шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хэргийг хянан хэлэлцэж, захиргааны зөрчлийг хянан шалгах, захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах, гомдол гаргах хугацааг дээрхи хуулиудын ерөнхий хугацаанаас богиносгож тогтоосноор процессын нэгдмэл нэг журам, хэлбэрээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг байх нийтлэг зарчмыг зөрчжээ.

Үүний улмаас байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод төрөөр баталгаажсан адил тэгш эрх, үүрэгтэй байх боломж алдагдсан байна.

Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод хэрэглэж буй хууль ижил, нэгдмэл байх нь хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байх гол болзол бөгөөд энэхүү болзлыг мөн зөрчсөн байна.

Хугацааг ялгавартайгаар тогтоож богиносгосноороо хэргийн бодит үнэнийг тогтоох, дүгнэлт гаргах, нотлох баримтыг шалгуулах, шүүхээр хамгаалуулах боломжийг хязгаарласан байна.

Ийнхүү хугацааг богиносгосноор эрх бүхий байгууллага асуудалд хөнгөн, хуумгай хандаж, хүний эрхийг зөрчиж иргэдийг хохироох хууль зүйн үндэслэл бий болгосон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1.Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл /Эрүүгийн байцаан шийтгэх хуульд 178.4; 225.5; 233.2; 302.4; 304.4; 309.4; 346.4 дэх хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйл /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 166.7; 174.2 дахь хэсэг нэмсэн/, 2 дугаар зүйл; Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг /Захиргааны хариуцлагын тухай хуульд 11.6; 19.8 дахь заалт нэмсэн/ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2.Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 06 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН
Л.РЭНЧИН
П.ОЧИРБАТ
Ж.АМАРСАНАА
Ч.ДАШНЯМ
Д.НАРАНЧИМЭГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэллэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс: 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 4